



УЛС ТӨР

Х.БАГТУЛГА: ЛУЙВРЫН
СОНГУУЛЬ БОЛСОН

ШУУРХАЙ МЭДЭЭ

ДААТГАЛД ХАМРАГДААГҮЙ УНААЧ
ХҮҮХДҮҮДИЙГ МОРЬ УНУУЛАХГҮЙ

II нүүрт

VII нүүрт

Дугаарын 60 мөр

Үнэгүй
үйлчлүүлэх ёстой
биш бил үү

Э. ТУУЛ

Улсын маань нийслэл Улаанбаатар нэг үеэ бодвол хөгжиж л байна. Өндөр сайхан дэлгүүр хоршоо, үйлчилгээний газрууд хаа сайгүй. Тав алхаад л зоогийн газар, баар ресторан, дэлгүүр хоршоо бий. Гэвч энд нэг л зүйл дутуу. Юу вэ хэмээвээс 00 буюу ариун цэврийн өрөө. Томоохон супермаркетэд орж үйлчлүүлэх зуураа ариун цэврийн өрөө хаана байгааг асуухад "Манайд 00 байхгүй" гэж хариулах нь энүүхэнд. Худалдагч, ажилтнууд нь ч хаана бие засдаг юм бүү мэд. Ямар ч байсан ийм хариулт сонсоод өнөөх цоожтой хаалга мөргөнө гэдэгтэй агаар нэг зүйл болно. Дараагийн алхам, баар, зоогийн газар.

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

ДОЛОО ДАХЬ УДААГИЙН ПАРЛАМЕНТ БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЖ ЭХЭЛЛЭЭ



Үргэлжлэл нь III нүүрт

Үргэлжлэл нь II нүүрт

Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Манай сонины III улирлын захиалга үргэлжилж байна

Улиралд 44 дугаар

Захиалгын үнэ 15400



Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай пост: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

ОНЦЛОХ МЭДЭЭ

З.Энхболд ажлаа өгч, Д.Эрдэнэбат намаа түр даргалахаар болов

Б.ТОГТОХ

2016 оны сонгуулиар бүлэг байгуулах хэмжээнд л ялалт байгуулсан АН-ынхан удирдлагууддаа хариуцлага тооцох ёстой хэмээн ялагдсаныхаа маргаашнаас ярьж эхэлсэн. Өнгөрөгч даваа гарагт гэхэд л намын дэргэдэх Шинэчлэлийн түр хорооны залуус АН-ын дарга З.Энхболдыг 24 цагийн дотор ажлаа хүлээлгэж өгөхийг шаардсан билээ. Тэгвэл өчигдөр АН-ын Гүйцэтгэх зөвлөл хуралдаж, АН-ын дарга З.Энхболдыг албан тушаалаас нь буулгажээ. Мөн Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Л.Эрхэмбаяр ч хариуцлагаа үүрэх аж. АН-ын ҮЗХ-ны хуралдаан энэ сарын 18-нд болох бөгөөд тус хуралдаанаар АН-ын дараагийн дарга хэн байх вэ гэдгийг шийдэх юм байна. Юутай ч ҮЗХ-ны хуралдаан

хүртэл Аж үйлдвэрийн сайд, УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбатыг түр намын даргаар томилжээ. Мөн өчигдөр тус хуралдаанаар бүлгийн дарга болон УИХ-ын дэд даргын томилгоог ч хийсэн юм. Д.Эрдэнэбат нь 2016 оны сонгуулиар сэлэнгчүүдийн итгэлийг хүлээж УИХ-д суусан билээ. Хоёр дахь удаагаа УИХ-ын гишүүнээр сууж буй энэ эрхэм 2012 онд АН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж, намаа ялалтад хүргэсэн, мөн АН-ын бүлгийг даргалж амжилттай ажиллаж, улмаар сүүлийн хоёр жил шинэхэн байгуулагдсан Аж үйлдвэрийн яамыг хөл дээр нь босгож чадсан билээ. Тиймдээ ч ҮЗХ-ны хуралдаанаар түүнийг жинхлэх магадлал маш өндөр байгаа бөгөөд намын гал тогоонд ажиллаж байсан туршлагатай улстөрчөөр удирдуулах хүсэл АН-ын жирийн гишүүдэд их байгаа аж.

ДОТОР НҮҮРТ

70 ЖИЛИЙН ТҮҮХТ "АЛДАР"-ЫНХАН ЭНЭ НААДАМД ӨНГӨТЭЙ БАЙНА



4-5

АЙЛЧЛАЛ

БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хэ Монгол Улсад албан ёсны айлчлал хийнэ



БНСУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд У Сун

Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотоор явахад солонгос хэлээр мэндлэх монгол хүмүүс олон тааралддаг. Зөвхөн мэндлээд зогсохгүй

солонгосоор чөлөөтэй ярьж, солонгосын олон ангит кино, солонгос дуу хөгжмийг сонирхдог, солонгос соёлыг мэддэг хүмүүс цөөнгүй. Монгол, Солонгос хоёр улс нь түүхийн урт удаан хугацаанд гарал үүсэл, соёл заншил, оюун санааны нарийн холбоотой явж ирсэн ах дүүсийн найрамдалт харилцаатай орнууд юм. Хоёр улс 1990 онд дипломат харилцаа тогтоосноор улс төр, эдийн засаг, худалдаа, нийгэм, соёлын зэрэг олон салбарын харилцаагаа хөгжүүлж, ялангуяа хоёр улсын иргэд хоорондын харилцаа хоёр орны харилцааны хөгжилд том хувь нэмэр оруулсаар ирсэн билээ. Үргэлжлэл нь III нүүрт

ХААН Банк

	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	1995.00	2013.00	ФУНТ	2590.00
ЕВРО	2187.00	2294.00	РУБЛЬ	29.10
ИЕН	19.13	20.00	ЮАНЬ	299.00

Хугалгаа хөгжлийн банк

	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	1997.00	2013.00	ФУНТ	2612.00
ЕВРО	2197.00	2274.00	РУБЛЬ	30.00
ИЕН	19.29	20.02	ЮАНЬ	298.30

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

ЖОТГОН

УИХ-ын 2016 оны сонгуульд Ардын нам 65 суудал, Ардчилсан нам ес, МАХН нэг, бие даагч С.Жавхлан нар ялалт байгуулсан билээ. Ерөнхийлөгчийн зарлигаар өчигдөр анхдугаар чуулган нээлтээ хийж, шинэ парламентын гишүүд тангараг өргөлөө. Ерөнхийлөгч долдугаар Их Хурлын анхны чуулганыг нээж хэлсэн үгэндээ “Монголын ард түмэн сонголтгоо хийлээ. Энэ бол дээд шийдвэр. СЕХ УИХ-д сонгогдсон гэсэн гишүүдийн нэрсийг надад өргөн барьсан. Иймээс УИХ-ын анхдугаар чуулган хуралдуулахад болон боллоо. Сонгуулийн ирц анх удаа өссөн дүнтэй гарсан. Сонгуулийн дүн гарах үйл явцыг тойрог, нэр дэвшигч тус бүрээр шууд дамжуулж харуулсан нь иргэд сонгогчдын талархлыг хүлэсэн” гээд парламентын шинэ гишүүдэд хандаж, Хариуцлагын тухай хуулийг хэлэлцэх, мэргэжлийн Засгийн газар байгуулах, иргэдийн талархал хүлээж байгаа ажлуудыг тасалдаггүй хөгжүүлэх, нээлттэй, тууштай төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах зэрэг анхаарал тавихыг сануулсан юм. Шинэ парламентын хэлэлцэх асуудлын эхэнд УИХ-ын даргыг томилж тухай асуудал эрэмблэгдсэн юм. МАН шинэ парламентын бүрэлдэхүүний 65 суудлыг авсан тул УИХ-ын даргыг намынхаа удирдах зөвлөлийн шийдвэрийн дагуу нэрийг нь оруулж ирэх эрх эдлэв. Энэ дагуу МАН-ын Удирдах зөвлөлийн шийдвэрээр намын дарга М.Энхболдыг нэрийг дэвшүүлж байгааг С.Бямбацогт уншиж танилцуулснаар гишүүдийн 86.8 хувийн саналаар дэмжигдэв. УИХ-ын даргыг томилж тухай асуудлыг хэлэлцэх үеэр УИХ-ын гишүүн Ц.Нямдорж үгээ хэлж, асуулт асуулаа. Тэрбээр “УИХ-ын гишүүн болсон бүх түшээддээ баяр хүргэе. Сонгуулийг амжилттай зохион байгуулсан СЕХ-ны нөхдүүдэд



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

баярласнаа илэрхийлэе. Сүүлийн жилүүдэд байхгүй тайван сонгууль болж өндөрлөлөө. 2004 онд будилаан, маргаан гарсан. 2008 онд бас маргаан гарсан. 2012 онд юу боллоо. Харин энэ удаад үнэхээр тайван, сайхан сонгууль боллоо. Түүнээс гадна би нэг зүйлийг хэлмээр байна. Дээрээ ард түмэнтэй, дэргэдээ сөрөг хүчинтэй гэдгийг аль ч үеийн парламентынхан битгий мартаарай гэдгийг 65 суудал авсан намынхаа нөхдөд зориуд захиж хэлмээр байна. Тэгээд би СЕХ-ны нөхдөөс ганц л зүйл асуумаар байгаа юм. Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах хэрэгтэй гэсэн зүйл та бүхэн анзаарагдсан уу. Тийм бол тодорхой хариулж өгөөч” хэмээсэн юм. СЕХ-ны дарга Ч.Содномцэрэн “Сонгуулийн хуулийг зайлшгүй өөрчлөх хэрэгтэй. Ойлогмжгүй зүйл, заалт маш олон байгаа. Тийм болохоор СЕХ-ноос энэ намартаа багтаад

Сонгуулийн тухай хуулийг УИХ-д өргөн барина” хэмээн хариулсан юм. Улмаар гишүүд үг хэлэх үеэр УИХ-ын гишүүн С.Эрдэнэ “Өнгөрсөн дөрвөн жил сөрөг хүчин байхдаа ярьж байсан асуудлуудаа ажил хэрэг болгоорой. Монгол төрийн албыг тогтвортой тууштай явуулах хэрэгтэй. Энэ асуудал дээр УИХ-ын даргын зүгээс хяналт тавьж ажиллаарай. Төрийн албанд ажиллаж буй иргэдийнхээ ажлын байрны баталгаанд анхаарах хэрэгтэй. Өнөөдөр ипотекийн зээлээ сар бүр төлдөг олон мянган төрийн албан хаагч байгаа гэдгийг сануулмаар байна” гэлээ. Мөн энэ үеэр УИХ-ын гишүүн Ө.Энхтүвшин “Намын дарга нь Засгийн газраа тэргүүлээд, намынхаа мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажилладаг жишиг байгаа. Тиймээс ч би Удирдах зөвлөлийнхөө шийдвэртэй санал нэгдэхгүй байна. Хамгийн гол нь нэг нүүртэй, амласандаа

хүрдэг байх хэрэгтэй. Хэдий нэг нам ч шударга бус зүйлийг би хэлээд явна гэдгээ энд хариуцлагатайгаар мэдэгдэж байна. Засгийн газар бүрдүүлэх асуудал бидний өмнө тулгарч байна. Мэргэжлийн Засгийн газраа бүрдүүлээд явах хэрэгтэй. Ажлаа хийж чадахгүй байгаа хэний ч толгойг илж болохгүй. Давхар дээлээ тайлах өмнөх санаачилгаа барьж ажиллахыг хүсье” гэв. Ийнхүү УИХ-ын даргын тамгыг М.Энхболд гардан авч, улмаар монголчуудад хандаж үг хэлсэн юм. Тэрбээр, “УИХ-ын даргын өндөр хүндтэй албан тушаалд нэрийг минь дэвшүүлсэн МАН, сонгож батламжилсан УИХ-ын эрхэм гишүүддээ талархал илэрхийлэе. УИХ-ын үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга зарчим, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зэрэг Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмуудыг

чанд баримтлан ажиллах болно. УИХ-ын гишүүний тангаргаа өргөсөн энэ мөчид УИХ-аас нэн тэргүүнд хэлэлцэн шийдвэрлэх асуудлууд байгаад Та бүхний анхаарлыг хандуулах нь зүйтэй гэж үзлээ. Бид мэргэжлийн Засгийн газрыг байгуулж нэн даруй үйл ажиллагааг нь эхлүүлэх шаардлагатай байна. Салбарынхаа үйл ажиллагааг бүхий л талаас нь мэддэг, мэргэшсэн төрийн зүтгэлтнээр Засгийн газрыг бүрдүүлж, төр, засгийн тогтвортой ажиллах нөхцөлийг хангана. Улс орноо өнөөгийн хямралт байдлаас гаргахын тулд шинээр бүрдэх Засгийн газар богино хугацаанд эдийн засгийн тогтворжуулах тусгай хөтөлбөр боловсруулан УИХ-аар батлуулах хэрэгтэй. Сөхөрсөн эдийн засгаа хөл дээр нь босгож, дундуур бүхнээ дүүргэн, дутуу бүхнийг бүтээж, айл өрх бүрийн амьжиргааг дээшлүүлэхийн төлөө бүхий л

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч: Ч.ЧУЛУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхэлсэн: Н.ПУНЦАГБОЛД

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.



С.Жавхлан монгол дээл, Б.Наранхүү футболкоор гангарав

Монгол төрийн парламент юутай ч бүрдэж чадлаа. Хэл амтай, хэрүүл тэмцэлтэй байсан ч 76 эрхэм маань тангарагаа өргөж, УИХ-ын гишүүний суудалдаа тухалжээ. Хэдийгээр нэг нам дангаар ноёлсон парламент бий болсон ч монголчууд ойрын хэдэн жилдээ л уйдаахгүй шинжтэй. Учир нь зохиолын дууны ханхүү эх оронч хөвүүн С.Жавхлан эхний өдрөөсөө л олны анхаарал татаж эхлэв. 99 морьтон дагуулааар хундан цагаан дээл, бор морь унасаар тэрбээр Төрийн ордонд гишүүний тангарагаа өргөхөөр ирж олны анхаарлыг татав. Дуулж эхэлсэн цагаасаа л эх орон, элгэн түмэн хамаг монголчуудынхаа төлөө тэмцэж яваа түүнийг “эх оронч” хэмээн дуудах болжээ. Гэвч өмнөх парламентад суусан цөөнгүй эх орончид сүүлдээ популист болж, хэн ч биш болоод суудлаасаа буусныг С.Жавхлан баяжатад сануулахгүй өнгөрч боломгүй юм. Ард түмний нүд чих нь байж, нэг намын дарангуйлал тогтсон парламентад зөвийг дэмжиж, бурууг шүүмжилж, багахан шуудай ажиллаарай гэж хүсье. Тэгвэл эх оронч хөвүүний хажууд энэ танхимд нэг удаа суугаад үзчихсэн УИХ-ын гишүүн Б.Наранхүү футболктой тангараг өргөхөөр ирсэн нь олны шүүмжлэл хүртэх шалтгаан болов. Монгол төрөө хүндэлж дээл биш юм гэхэд ядахдаа албаны хувцастай ирж болсонгүй юу, энэ хүн бизнесийн уулзалтад амарч зугаалахдаа яваагүй биз дээ гэх мэтээр сөрөг сэтгэгдэл их байх аж. Монгол төрийн босго намсан байлаа ч Төрийнхөө ордонд тангараг өргөх гээд ирж байгаа эрхэм гишүүнд ядахдаа ганц цагаан цамц олоогүй гэж хэлэхгүй байлгүй. Тэр түмэн олноо бас Төрийн ордоо ч доромжиллоо. Юутай ч өнгөрсөн дөрвөн жилд гэгээн дүрээ нэг өдөр ч харуулаагүй эрхэм гишүүн футболктой ч болов ирж тангараг өргөсөн нь их “завшаан” юм даа. Төрсөн эгч нь эрхбиш цаашдаа зөвлөлд явах байлгүй гэж найдахаас.

Ээлжит сонгуулиас хойш хөшигний цаана наана өрнөж байсан таамаг дуусч МАН-ынхан УИХ-ын даргаа томиллоо. Өөрөөр хэлбэл, ирэх жилийн Ерөнхийлөгчийн сонгуульд МАН-аас нэр дэвших хүн тодорхой боллоо гэсэн үг. Ялсан намын дарга Ерөнхий сайд болох ёстой хэмээн чуулганы индрээс эсэргүүцэл илэрхийлж байсан МАН-ынхан ийн ялсан намынхаа даргыг

УИХ-ын даргаар томилж, өөрсдөө эсэргүүцэж байсан үйлдээ хийв. Юутай ч 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуульд С.Баяр, У.Хүрэлсүх ч биш хотын фракцийн төлөөлөл болох М.Энхболд нэр дэвших нь тодорхой болж байна. Харин одоо дараагийн нүүдэл бол МАН-ын хүсч хүлээдэг “мэргэжлийн” Засгийн газрыг хэн толгойлох вэ гэдэг асуудал. Н.Энхболд, У.Хүрэлсүх,



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

МАН-ын мэргэжлийн Засгийн газар өвгөчүүлээр дүүрэх вий

Ж.Эрдэнэбат гэх мэтээр таамаг дэвшүүлэх хүн дэндүү олон. Тэгвэл албан бус эх сурвалжийн мэдээлж буйгаар Ерөнхий сайдад Ж.Эрдэнэбатыг нэр дэвшүүлэхээр болсон гэх яриа байна. Мөн С.Бямбацогт ч нэр дэвшихээр санаархаж эхэллээ. МАН-ынхан энэ удаад өнөөх л улиг болсон өвгөчүүлээр биш тухайн салбарынхаа талаар мэддэг, тэр хэрээр туршлага хуримтлуулсан туршлагатай

залуу улстөрчдөд боломж олгох учиртай гэдгийг хүн бүхэн хүлээж буй билээ. Төрийн тамга атгаж үзээгүй нях Сэнгүмээс гадна энэ намд салбар бүртээ мэргэшсэн боловсон хүчин олон бий. Нэг суудалд хадчихсан аятай монгол төрийг 30, 40 жил даргалсан өвгөчүүлээсээ илүү эдгээр чадварлаг боловсон хүчинүүддээ боломж олгоно гэсэн хүлээлт, ард түмний итгэл рүү эрхбин ус цацахгүй гэж

найдыа. МАН-ын дарга ч сая УИХ-ын даргын тамгаа авахдаа Мэргэжлийн Засгийн газрыг байгуулаа хэмээн мэдэгдчихлээ. Албан тушаалд очихоороо хэлсэн ярьснаа мартдаг гэдгээ намын даргаа УИХ-ын даргаар томилж харуулаа, МАН-ынхан. Одоо мэргэжлийн Засгийн газар байгуулах тэмцлээсээ хойшоо ухарвал ард түмний итгэл юу болж хувирч билээ гэдгийг тунгаах биз ээ.

хүчээ дайчлан хичээнгүйлэн зүтгэх болно” хэмээлээ. Ингэснээр шинэ парламентын анхдугаар чуулганыг түр завсарлуулж, дунд нь намын бүлгүүд хуралдаж бүлгийн дарга болон УИХ-ын дэд дарга нараа томилсны дараа хуралдахаар болов.

АН-ын бүлгийг С.Эрдэнэ, МАН-ын бүлгийг Д.Хаянхярваа даргална

Анхдугаар чуулганы дараа АН-ын дарга З.Энхболд УИХ-д сонгогдсон намынхаа гишүүдэд баяр хүргэж, Гүйцэтгэх зөвлөлөө хуралдуулсан юм. Хуралдаанаар С.Эрдэнэ гишүүнийг УИХ дахь АН-ын бүлгийн даргаар сонгосон. Мөн тус намын зүгээс УИХ-ын дэд даргаар Я.Санжмятавыг томилж шийдвэр гаргав. Харин МАН-ын бүлгийн даргаар Д.Хаянхярвааг сонгосон юм. Бүлгийн хуралдааны дараа УИХ-ын анхдугаар чуулганы үдээс хойших хуралдаан 17.30 цагаас гишүүдийн 82.9 хувийн ирцтэйгээр хуралдаж, УИХ дахь намын бүлгүүдийг баталж, мөн бүлгийн дарга нарыг баталлаа. Өөрөөр хэлбэл, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар УИХ дахь МАН-ын бүлгийн даргаар УИХ-ын гишүүн Д.Хаянхярвааг сонгосон тухай танилцуулснаар эрх үүргээ хэрэгжүүлж эхэллээ. Мөн УИХ дахь Ардчилсан намын бүлгийн даргаар нь УИХ-ын гишүүн С.Эрдэнийг сонгосон тухай УИХ-ын дарга М.Энхболд танилцуулснаар бүлгийн эрх үүрэг нь хэрэгжиж эхэлсэн юм. Харин УИХ-ын дэд дарга нарын хувьд МАН-ын бүлгээс УИХ-ын гишүүн Ц.Нямдоржийг нэр дэвшүүлснийг гишүүдийн 97.1 хувийн, Ардчилсан намын бүлгээс УИХ-ын гишүүн Я.Санжмятавыг нэр дэвшүүлснийг гишүүдийн 95.8 хувийн тус бүр дэмжин баталсан юм. Санал хураалтад нийт 72 гишүүн оролцсоноор чуулганы хуралдаан завсарлалаа. Намууд өчигдөрөөс эхлэн албажиж, улмаар өнөөдөрөөс эхлэн бүлэг доторхи томилгоогоо хийж, улсын төсвийн тодотгол, ирэх оны төсвийн төсөөллийг хуваарийн дагуу хэлэлцэх эхлэх нь ээ.

МЭДЭЭЛЭЛ

Х.Баттулга: Луйврын сонгууль болсон

Ардчилсан намын дарга З.Энхболд, МАХН-ын дарга Н.Энхбаяр, УИХ-ын гишүүн Х.Баттулга нар мэдээлэл хийлээ. Ардчилсан намын дарга З.Энхболд “Энэ сонгуулийн үр дүнг зайлшгүй нягтлах ёстой. Дархан-Уул аймгийн иргэн З.Дугармаа гэж хүн хоёр удаа санал өгсөн. Тэрбээр өөрийнхөө нэрээр саналаа өгчөөд дараа нь Н.Отгончимэг гэж хүний оронд санал өгсөн. МАН-ын гишүүн Дугармаа гэж хүн хоёр удаа санал өгөх ёсгүй. Гэтэл бүртгэлийн байгууллага түүнд хоёр дахин санал өгөх эрх өгсөн байгаа. Энэ бол хууль зөрчсөн ноцтой үйлдэл. Сонгуульд булхай луйвар ямар нэг хэмжээгээр орсон нь тодорхой будилаануудаар нотлогдоод байна. Гэтэл Сонгуулийн ерөнхий хороо, Бүртгэлийн байгууллага, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн байгууллага өөрөө нүдээ анхсан нь хуйвалдаан хэр том хэмжээтэй болсныг харуулж байгаа. Энийг цаг алдалгүй тогтоох ёстой. 14 хоног шаардлагатай. Байгууллагын дарга нарыг нь ажлаас чөлөөлдөг юм уу, ингэж байж шалгахгүй бол одоо ул мөрөө арилгах ажил

эхэлсэн. Одоо Ерөнхийлөгчтэй уулзаж, УИХ-ын анхдугаар чуулганыг хойшлуулах саналаа хэлнэ” гэлээ. Харин МАХН-ын дарга Н.Энхбаяр “АН-д шүүмжлэлтэй хандсан юм бий, гэхдээ ингэглээ нэр хүнд нь унаагүй. МАХН ганцхан суудалтай болтлоо нэр хүнд унасан гэж бодохгүй байна. Луйвардлаа гэхэд хэмжээ хязгаартай луйвардаж болно, хэтрүүлээд цэвэр булхай гэдэг нь авсан тооноос нь харагдаж байгаа. Ардчилсан намын алдаа дутагдал дээр тоглож байгаад нэр хүндээ өгсгөсөн байж болно, гэхдээ 60 тэрбумын луйвар нь энэ хэмжээнд очихгүй” хэмээлээ.

Энэ үеэр УИХ-ын гишүүн Х.Баттулга “Баянхонгор аймагт шүүхийн шийдвэр гарсан, нотлох баримт хангалттай гарсан. Луйврын сонгууль болсон. Хөвсгөл, Увс мөн ийм юм болсон. Хүчний байгууллагуудыг бүгдийг өөртөө авсан байна” гэдгийг дуулгасан юм. Ийнхүү З.Энхболд, Н.Энхбаяр нар Ерөнхийлөгчтэй уулзаж анхдугаар чуулганыг хойшлуулах саналыг Ерөнхийлөгчид тавьсан юм байна.

ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр

Үнэгүй үйлчлүүлэх ёстой биш бил үү

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Тэнд орж үйлчлүүлээгүй хүн бол “төлбөр” төлөхөөс өөр аргагүй. Тиймээс л 00 гэдэг манайхны тулгамдсан асуудлын нэг яах аргагүй мөн. Угтаа бол манайхаас өөр оронд үйлчлүүлэгчээсээ 00-ын төлбөр нэхдэггүй. Дээрээс нь үйлчилгээний байгууллага болон олон нийтийн газрууд, захуудын 00 гэж авах юм байхгүй. Манайд ирсэн жуулчид бие засах газар олдохгүй нь үнэхээр бэрхшээлтэй байлаа гэж зовлон тоочдогтой нэгэн ажил хөдөөнөөс ирсэн хүмүүс ч үүнийг хэлдэг. Тэр байтугай хотын оршин суугчид гэр, ажлаасаа тав алхаад л бие засах газаргүйн зовлонг амсана. Гадуур явж байгаад ариун цэврийн өрөө орох шаардлагатай болсон хүмүүст гэр хүртлээ давсгаа чинэрүүлэн тэвчих, эсвэл шингэн зүйл бага уух гэсэн хоёрхон сонголт л үлдэнэ. Амьд хүн аргатай гэгчээр зарим нь аль нэгэн ресторан, цайны газраар үйлчлүүлээгүй атлаа, мөнгөө төлөөд аргална. Бүр болохгүй бол олны нүдэн дээр гудамжинд морь харахаас өөр аргагүй. Ингээд нийслэлд өвчлөөд шээсэн бүрхүүл тогтож, зундаа шивтэр ханхалдаг болоод удаж байна. Эмч мэргэжилтнүүдийн хэлж байгаагаар хүний бие бодисын солилцоонд орж, хамгийн хэрэггүй зүйлээ шээсээрээ дамжуулж гадагшлуулдаг гэдэг. Шээс эрдэс бодис, хортой бүтээгдэхүүнүүд, даавар, бодисын солилцооны задралын бүтээгдэхүүн агуулдаг бөгөөд хүний шээсээр дамжин гарсан хэрэгцээгүй бодисууд агаарт дэгдэн олон тооны өвчин үүсгэгч нян бактериуд бий болгож амьсгалын замын болон халдварт өвчин үүсгэдэг гэнэ билээ. Дээрээс нь манайхан давсагийн үрэвсэл ихтэй байдаг. Давсаг хэт томтой, давсагны хатууралтай байх нь ихэссэн гэсэн. Энэ бол өдөржин

бие засахгүй явчихдагтай ч холбоотой байж мэднэ. Уг нь “Нийслэлийн худалдаа үйлчилгээний журам”-аар нийтийн үйлчилгээний газрын ариун цэврийн өрөөгөөр үйлчлүүлэхэд төлбөр хураамж авдаг тогтолцоог үгүй болгосон санагдана. Аль 2014 оноос л энэ журам хэрэгжиж эхэлсэн гэж байгаа ч өнөөдрийг хүртэл бид 00-ын төлбөр төлсөөр байгаа шүү дээ. ШӨХТГ-ынхны хэлж байгаагаар нийслэлийн төвийн зургаан дүүргийн Засаг даргад нийтийн үйлчилгээний газруудын бие засах газрыг төлбөргүй болгож, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах ажил зохион байгуулах мэдэгдлийг хүргүүлсэн гэж байгаа. Түүнчлэн “Нийслэлийн худалдаа үйлчилгээний журам”-ын 4.18-д зааснаар үнэ төлбөргүйгээр ариун цэврийн өрөө ажиллуулах газарт үзвэр үйлчилгээ, эмнэлэг, томоохон зах, худалдааны төв, супермаркетуудын 00 бүгд төлбөртэй байна. О.Магнай ШӨХТГ-ын даргаар ажиллаж байхдаа энэ байдалтай гэмцэж, бүр өөрийн биеэр очиж журмын биелэлтэд хяналт тавьж байхад дээрх газрууд 00-ын төлбөр авахаа түр зогсоосон. Гэтэл О.Магнай ажлаа хүлээлгэж өгсний дараа өнөөх 00-ууд төлбөртэй болох нь тэр. Яагаад хэрэгжүүлэх ёстой журмыг хэрэгжүүлээд явчихалгүй, нэг дарга солигдоход өөрчлөгдөх ёстой гэж. Хэдхэн хүний эрх ашгаас илүү нийслэлчүүдийн эрх ашиг том байх учиртайсан. Тиймээс ШӨХТГ-ынхан ажлаа хийж эхэлмээр байна. Давсагны үрэвсэлтэй болж, хорт бодисууд амьсгалааа одоо зогсоомор байна. Яагаад ганц 00-ын асуудлаас болж, эрүүл мэндээрээ хохирох гэж. Хэрвээ 00-ын асуудлаа шийдэж чадахгүй бол эрүүл мэндийн зардлаа холбогдох газраас нь нэхнэ шүү.



БОЛОВСРОЛТОЙ НЬ ГОЛОГДОЖ “БОР ХАЛЗАН ХОНЬ” ОД БОЛСОН ПАРЛАМЕНТ

Гэрэл зурагч Г.АРГУУЖИИ

Б.ӨНӨРТӨГТӨХ

2016 оны УИХ-ын сонгуулиар ялалт байгуулсан 76 төрийн түшээ маань түмэн олноо төлөө хоёргүй сэтгэлээр ажиллахаа өчигдөр тангараг өргөж батлав. Өнөөдрөөс эхлэн тэд дуучин, бөх, яруу найрагч, аль нэг компани, дэлгүүрийн эзэд биш ард түмнийхээ төлөө тангараг өргөсөн төрийн түшээ болж байна. Монгол төрийн баганын нэг болж, монголчуудын сайн сайхны төлөө өөрийн эрх ашгаа хойш тавьж ажиллах үрхэтгэй болж байгаа юм. Монголчууд энэ удаад уламжлалт хандлагаар сонголт хийсэн. Өөрөөр хэлбэл, 90 жилийн түүхтэй МАН-ынханд хуучнаа санагдсан үнэмлэхүй ялалт өгснөөр өчигдөр тангараг өргөсөн парламент хамгийн сүл сөрөг хүчинтэй, гуравдагч хүчин болон бие даагчийн дуу хоолой дуудахгүй шахам, нэг намын дангаар ноёрхсон парламент боллоо. Нэг нам дангаар УИХ-ыг бүрдүүлэх нь зарим талаараа давуу талтай. Ядахдаа л төрийн бодлого шийдвэр сөрөг хүчний шантааж, гуравдагч хүчний хоржин улс төрийн золионд орж гацаж зогсохгүйгээр батлагдах боломжтой. Бие даагчид кнопоор “бие үнэлдэг” асуудал арилж буй нь сайшаалтай. Гэвч нөгөө талд өнөөх л авлига албан тушаалын наймаа цэцэглэж, нэг намынхан юу хүссэн шийдвэрээ ямар ч хяналтгүй гаргах, төрийн бодлогоор наймаа хийж, том ордыг хэний ч хяналтгүйгээр тавиад туучих бололцоог бүрдүүлсэн нь харамсалтай. Ядахдаа л энэ удаад өмнөх 2012 оны сонгууль шиг хүчтэй сөрөг хүчинтэй байж чадсангүй, бид. Гэвч эрийг бүү бас далайг бүү янд гэгчээр АН-ын есөн гишүүний ихэнхи нь УИХ-д хоёроос дээш суучихсан, МАН-ын зан ааш, үг үйлдлийг мэдэх болсон гишүүд учраас ямар асуудлаар хор найруулж, ард түмний эрх ашгийг улаандаа гишгэлж буйг өдөр болгон иргэддээ мэдээлж, чамлахааргүй сөрөг хүчин болж ажиллаж чадах нь дамжиггүй билээ. Тийм байхыг ч ард түмэн шаардах нь тодорхой.

40 “бор халзан хонь” –той парламент

Юутай ч өчигдөр анхдугаар хуралдаанаа элдэв хэл амгүй хийж, тангарагаа өргөж, УИХ-ын дарга, дэд дарга томилж, бүлгээ албажууллаа. Хууль бус чуулган болж байна гэх яриа АН, МАХН-ын дарга нараас гарч байсан ч Ерөнхийлөгчтэй уулзсаны дараа тэд “бууж өгсөн” юм. Шинэ парламент тангараг өргөж, өмнөх УИХ-ын гишүүдийн бүрэн эрх дуусгавар болсноор өчигдрөөс эхлэн ордонд нүүдэл суудал эхэлжээ. Гэртээ сууж байгаад төр түшиллэхээр ороод ирсэн МАН-ын “бор халзан хонинүүд” хэсэгтэй л өрөөгөө олохгүй, Төрийн ордондоо төөрөх шинжтэй. Ганц нам дангаар ноёлсон ч ирэх дөрвөн жилд бид төр түшиллэх хүмүүстэйгээ тун ч хөгжилтэй байх нь тодорхой

...Монголын тэргүүн компаниудын нэг MCS компани өнөөгийн УИХ-д хоёр ч төлөөлөлтэй болов. Тодруулбал, Хөвсгөл аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан, Баянхонгор аймгаас УИХ-д суусан Л.Элдэв-Очир нар тус компанид хариуцлагатай алба хашч байсныг ард түмэн мэдэж буй...

байна. Тухайлбал, АН-аас төрийн эрх барихаар орж ирсэн ганц эмэгтэй улстөрч З.Нарантуяа өөрийгөө тангараг өгүүлэхгүй хэмээн кнопоо андуурч даран олны инээдийг барав. Түүнчлэн, Зохиолын дууны ханхүү, УИХ-ын гишүүн С.Жавхлан 99 морьтон эрс дагуулсаар Төрийн ордонд морилсон нь ёстой л үзүүштэй үйл явдал боллоо. Төрийн ордонд гадна морьтой, цав цагаан дээлтэй морилсон эрхэм төрийн түшээ ташуураа барьсаар Төрийн ордонд орж ирэн тангараг өргөсөн юм. Тэрбээр, УИХ-ын гишүүний түр үнэмлэх гардаж авахдаа УИХ-ын 76 гишүүнийг дээд өмсгөж сургана хэмээсэн бөгөөд түүний үгийг юутай ч МАН-ын 12 эмэгтэй гишүүн биелүүлж, 12-уулаа дээд өмсч иржээ. Энэ мэтээр үзэх харах зүйл ихтэй байх нь дамжиггүй. Нөгөө талаар МАН, АН-аас энэ удаа 39 будаг нь ханхалсан шинэ гишүүн орж ирлээ. Энэ нь парламентын бараг тал хувь гэсэн үг. Эндээс харахад, ирэх дөрвөн жилд УИХ-ын хууль тогтоомж 36 гишүүний бодлого шийдвэрээр л гарч байна гэсэн үг. Харин үлдсэн 40 нь үнэнийг хэлэхэд, УИХ-ын гишүүн яаж болсныг таах аргагүй. Тэд хууль болговруулж, баталж, байнгын хороог даргалах гэхээс илүүтэй кнопоо зөв дарж, хуулийн төсөл хэдэн шат дамжлагаар боловсруулагддаг, улсын төсөв гэж юу байдаг талаар уншиж судлахад л энэ дөрвөн жилийг зарцуулах нь ээ. Эхний нэг жил Төрийн ордондоо төөрчихгүй

өрөөгөө олж байвал их юм болох билээ. Энэ доромжилсон асуудал биш. Чин үнэнийг хэлэхэд, бодит байдал ийм л байна. Тиймээс төрийн хуулийг батлах туршлага суусан гэж харж буй үлдсэн 36 гишүүн кнопоор багахан шиг тоглож, ард түмний өмнө өргөсөн тангарагаа биелүүлж хууль боловсруулах ажлаа чин үнэнчээр хийгээсэй гэж хүлээх л үлдлээ.

Нялх Сэнгүм, компанийн эздээр Төрийн ордон дүүрлээ

Баян айлын өв залгамжлагч хөвүүд энэ удаад олон бий. УИХ-ын гишүүн МАК-ийн эзэн Нямтайширын хүү Номтойбаяр, Эрдэнэт үйлдвэрийн захирал асан Ч.Ганзоригийн хүү Тэмүүлэн, “Их засаг” их сургуулийн захирал Ням-Осорын хүү, “Роял” академийн захирал, Чингис СООСЭ их сургуулийн захирал, Учрал, Отгонбилэгасаныхүү “Петровис” компанийн захирал Содбилэг гэх мэтээр өв залгамжлагчид өнөөгийн парламентад олноор сууж байна. Цаашлаад бизнесийн салбарынхан энэ удаад тун ч одтой байлаа. Монголын тэргүүн компаниудын нэг MCS компани өнөөгийн УИХ-д хоёр ч төлөөлөлтэй болов. Тодруулбал, Хөвсгөл аймгаас сонгогдсон УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалан, Баянхонгор аймгаас УИХ-д суусан Л.Элдэв-Очир нар тус компанид хариуцлагатай алба хашч байсныг ард түмэн мэдэж буй. Цаашлаад, “Монполимет” группийн эзэн Ц.Гарамжав, “Бишрэлт” группийн эзэн Б.Ундармаа, “Билэг” их дэлгүүрийн эзэн Б.Билэгт, “Оргил” худалдааны төвийн эзэн Ж.Ганбаатар, Содмонгол группийн эзэд болон захирлуудын төлөөлөл, “Дорнын говь” компанийн захирал Б.Дэлгэрсайхан, “Хурд” группийн эзэн Б.Чойжилсүрэн зэргээр монголын тэргүүлэгч компаниудын эзэд маш олноор УИХ-д орж ирлээ. Эдгээр хүмүүс чин үнэнийг хэлэхэд, ирэх дөрвөн жил ард түмний эрх ашгийн төлөө юу, эсвэл улсын төсвөөс өөрийнхөө компанид өчүүхэн хэлтэрхийг оруулахын төлөө ажиллах уу гэдгийг хэлэхэд эргт байна. Улс төрд өмнөх жилүүдэд бизнесмэнүүд өөрийн бизнесээ л өргөжүүлэх гэж ордог бичигдээгүй хуультай байлаа. Тиймдээ ч эдгээр том компанийн эзэд төрийн бодлогыг түмний төлөө гаргаж ажиллана гэдэг итгэл төрөхгүй байгааг нуух аргагүй билээ.

Төрийн бодлогод түй ч хэрэггүй түшээд

Өмнө хэлсэнчлэн, ард түмэн өнөө жил өмнөхөө дурссан, хуучнаа санагдсан сонголт хийсэн. Эрх барьж байсан АН-ын дураараа дургисан үйлдэл, сонгуулийн хуулийн тогтолцооны гажгаас үүдэж энэ удаагийн парламентад төсөөлж байгаагүй олон “бор халзан хонь”-ууд

БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хэ Монгол Улсад албан ёсны айлчлал хийнэ



Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Өнөөгийн байдлаар Монгол Улсын нийт хүн амын 1 хувьд ногдох буюу 30 мянган монголын иргэд солонгост оршин сууж байгаа бөгөөд энэ нь нийт гадаадад оршин сууж буй 150 мянган монгол иргэдийн 20 хувийг эзлэж байгаа юм. Сурах, хөдөлмөрлөх зорилгоор солонгост удаан хугацаагаар оршин сууж байгаад буцаж ирсэн монгол иргэд бол бидний дипломат харилцааны томоохон баялаг гэж хэлж болно. Энэ оны 5-р сард Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж БНСУ-д албан ёсны айлчлал хийсэн бол БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хэ

АСЕМ-ийн Дээд түвшний уулзалтыг тохиолдуулан Монгол Улсад албан ёсны айлчлал хийхээр боллоо. Хоёрхон сарын дотор хоёр улсын төрийн тэргүүн харилцан айлчлал хийх нь бусад улс орнуудаас ч харахад ховор тохиолдол бөгөөд энэ нь тэр хэрээр хоёр улсын харилцаа чухал ач холбогдолтой байгааг харуулж байна. Монгол Улс нь геополитикийн хувьд чухал байрлалд оршдог. Зүүн хойд Ази, Төв Азийн аль алинд хамрагдах хэмжээний хоёр бүс нутгийг холбодог, Монголыгээр Еврази тивийг ярих боломжгүй билээ. Манай улс Евразийн улсуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд Монгол Улсын газарзүйн байршил улам чухалд тооцогддог. Монгол Улс нь Солонгосын хойгоос долоо дахин том өргөн уудам газар нутагтай, газрын арвин баялгаараа дэлхийд эхний 10-т ордог боловч далайд гарцгүй эх газрын улс тул тээвэр ложистикийн хязгаарлагдмал байдалтай. Тиймээс уг хязгаарлагдмал байдлаа даван туулахын тулд Пак Гын Хэ Ерөнхийлөгчийн дэвшүүлсэн “Евразийн санаачлага”-ыг идэвхтэй дэмжсээр ирсэн билээ. Өнгөрсөн жилийн 7-р сард Бээжин хотоос хөдлөсөн Евразийн нөхөрлөлийн тусгай галт тэрэг Улаанбаатарыг дайран Иркутскт хүрсэн нь Ази, Европыг холбосон хамгийн дот замыг батлан харуулж, Монгол Улс Евразийн зам тээвэр, эрчим хүч, эрдэс баялаг, худалдааны сүлжээг бий болгоход чухал бааз улс болохоо дахин харуулж анхаарал татлаа. Пак Ерөнхийлөгч АСЕМ-ийн Дээд түвшний уулзалтанд оролцож Еврази тивийг хамарсан өргөн хүрээнд гадаад бодлогын байр сууриа илэрхийлж, Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржтой геостратегийн чиглэлээр нарийн судалгаанд суурилсан хоёр улсын харилцааны хамтын ажиллагааны цаашдын арга замын талаар хэлэлцэх болно. Монгол Улс Сөүлээс онгоцоор ердөө гурван цаг яваад хүрэх ойр улсууд бөгөөд өнөөг хүртэл Монгол, Солонгос хоёр улсын харилцааны хөгжлийн хурдаас харахад цаашид ч улам хөгжин дэвжих нөөц бололцоо бүрэн байна. Пак Ерөнхийлөгчийн энэ удаагийн айлчлалаар тэрхүү нөөц бололцоог бодит болгож хоёр улс харилцан ашигтай хөгжиж түншлэлийн харилцаагаа бататгана гэж найдаж байна.

РЫН СУРВАЛЖЛАГА



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Б.ДАВАА

Тулгар төрийн 2225, Их Монгол Улсын 810, Ардын хувьсгалын 95 жилийн ойн их баяр наадам болоход ердөө тав хоногийн хугацаа үлджээ. Наадам дөхсөн эл өдрүүдэд бөхийн галыг зорьсон цуваа ч тасардаггүй. Энэ жил хэн гэдэг бөх өнгөтэй байгаа, хэн хаана бэлтгэлдээ гарсан зэргийг сонирхсон бөхийн хорхойтнууд бөхчүүдээ эргэн бэлтгэлийг нь сэм сонирхон наадмыг хүлээж буй. Тиймээс “Монголын мэдээ” сонинны сурвалжлах баг энэ удаа 70 жилийн түүхтэй Батлан хамгаалах яамны дэргэдэх “Алдар” спорт хорооны бөхийн галыг зорилоо. Хурмаст тэнгэр хур бороогоо энэ жил харамгүй хайрласан болохоор ч тэрүү хөдөө нутаг ногоорон мэлтийж, өнгө өнгө цэцэгс алаглаж хаа нэгтэйгээс таатай үнэр хамар цоргин ахуйд нэг мэдэхэнэ л Төв аймгийн Алтанбулаг сумын “Пинтийн ам” гэх газарт байрлах “Алдар” спорт хорооны сургалтын баазад ирчихсэн байв.

“Алдар”-ынхан
бэлтгэлдээ гараад 20
гаруй хоножээ

Биднийг очих үед Алдарынхан бэсрэг наадамд бэлдээд завгүй байлаа. Гурван том асар барьж, бөхчүүд нь зодог шуудаа, харваачид нь үндэсний хувцсаа өмсч, хурд хүч, цэц мэргэнээ сориход бэлтгэж байв. Жил бүрийн долдугаар сарын эхээр Батлан хамгаалах яам, зэвсэгт хүчний удирдлагууд “Алдар” спорт хорооныхоо бөхийн галд зочилж, бэсрэг наадам хийж бөх, харваачдынхаа өнгийг



шинждэг уламжлалтай. Өмнө нь тус спорт хорооны бүх бөхчүүд нэгдсэн бэлтгэлд гардаг байсан бол сүүлийн жилүүдэд нутаг нутгийнхаа дэвжээний бөхчүүдтэй хийдэг болсон бөгөөд энд “Өмсдөг” Ш.Зоригтын удирдлага дор ихэвчлэн залуу бөхчүүд бэлтгэлээ базаадаг гэнэ. Харин наадам дөхөж долдугаар сар гармагц тал талаас бөхчүүд “Пинтийн ам”-д цугларч, бэсрэг наадам зохион байгуулдаг уламжлал тогтоод үлджээ. Бусад спорт хороодыг бодвол илүү өргөн бүрэлдэхүүнтэй гэж хэлж болох “Алдар” спорт хороонд улс, аймгийн цолтой 70 орчим бөх бий. Энэ жилийн хувьд ихэнх цолтой бөхчүүд нь аймаг, аймгийнхаа нутгийн дэвжээдийн галд бэлтгэлдээ гарчээ. Тухайлбал, Архангай аймгийн галд Дархан аварга Г.Өсөхбаяр, Улсын заан Ч.Санжаадамба, Улсын харцага Т.Мөнгөнцоож нарын бөхчүүд бэлтгэлээ базааж буй бол Увс нуурын галд арслан Б.Ганбат, П.Бүрэнгэс нарын бөхчүүд, Сэлэнгэ аймгийн “Таванхаан” дэвжээнд аймгийн арслан Б.Одгэрэл нарын бөхчүүд, Булган аймгийн “Булган хүчтэн” дэвжээнд Улсын начин И.Ёндонсамбуу, О.Цогтгэрэл нар наадмын бэлтгэлдээ гарчээ. Завхан аймгийн дэмжээнд Улсын гарьд Б.Гончигдамба тэргүүтэй бусад бөхчүүд гарсан байх бөгөөд энэ мэтээр тус тус нутгийнхаа дэвжээнд гарч байгаа юм байна. Харин “Пинтийн ам” дахь үндсэн галд аймгийн арслан Н.Мустапа, Аймгийн арслан Б.Серик, Бүх цэргийн начин П.Түмэнжаргал болон бусад залуу бөхчүүд гээд нийтдээ 20 гаруй бөх наадмын бэлтгэлдээ гараад 20 гаруй хонож байгаа ажээ. Алдар спорт хорооны Үндэсний бөхийн дасгалжуулагч

бөх сонирхогчид дундаа “Өмсдөг Зоригт” гэх нэрээр танигддаг Улсын начин Ш.Зоригт үндсэн гал дээрээ байрлаж, залуу бөхчүүдээ наадамд бэлтгэж байна.

“Торгон ирэнд нь
тохируулах үедээ явна”

Манай сурвалжлах баг бэсрэг наадам эхлэхээс урьтаж, улсын начин Ш.Зоригтоос наадмын бэлтгэл хийгээд бөхчүүдийн өнгө ямар байгааг асууж тодрууллаа. Тэрбээр бидэнд бөхийн нэр цохож хэлэхээс цэрвэж байсан ч, хэд хэдэн бөх нь шинээр улсын цолд ойртож, харин цолтой бөхчүүд нь аварга болох болов уу хэмээн таамаглаж буйгаа нуугаагүй. Түүнээс бөхчүүдийн бэлтгэл ямар шатаандаа яваа талаар тодруулахад, “Бэлтгэлийн хувьд үндсэн үе дуусаад сэргэлт, амрайтны үе буюу тактик техникээ боловсруулах үедээ орсон байна. Морниор ярьбал торгон хэлэндээ тохируулах үе шатаандаа явна даа” гэлээ. Ш.Зоригтын таамаглаж буйгаар “Алдар” спорт хорооны 20-30 аймаг, цэргийн цолтой бөхчүүд улсын цол авах боломжтой бөгөөд 3-4 улсын начин төрөх магадлал өндөр байгаа ажээ. Бүр шинэ аваргатай болох болов уу гэсэн горьдлого тээж байгаагаа тэрбээр бидэнд хуучилсан юм. Тэдний бэлтгэлээр хэрхэн базаасныг илтгэх мэд зодог шуудаагаа өмссөн бөхчүүдийн арьс нь нарны гэрэлд түлэгдэж борлосон харагдсан юм. Уул ус нь тэгширсэн байгалийн үзэсгэлэнт газар 20 гаруй хоног бэлтгэлээ базаасан бөхчүүд борлох нь ч аргагүй биз. Ингээд Ш.Зоригт начингаас бэсрэг наадам эхлэхээс урьтаж, хэдхэн хором хөөрөлдсөнөө уншигчиддаа сонирхуулаа.

Ш.Зоригт: Анх удаа
барилдаад аймгийн
арслан цолтой бөхийг
давж байсан минь
санаанаас гардаггүй

“Алдар” спорт хорооны
дасгалжуулагч, Улсын начин/
-Энэ жилийн наадмын
онцлог нь юу байх вэ. Өмнө
нь есөн даваатай байсан бол
энэ жил 10 даваатай болсон
байгаа. Өмнөх наадмуудаас
юугаараа өөр байх вэ?

-Энэ жилийн наадам маш онцлогтой болно. АСЕМ-ыг зохион байгуулж буйтай холбоотойгоор бүх аймаг сумдын наадмыг Улсын баяр наадмаас хойш зохион байгуулна. Тиймээс бөхчүүд бүгд улсын наадамдаа барилдана гэсэн үг. Энэ жил 1024 бөх барилдана. Бэлтгэл сайтай маш олон бөх барилдах тул даваа бүр чанга байх нь тодорхой. 1024 бөхөөс үзүүр түүрүүнд хүрч чадвал аварга болох боломжтой байгаа. Мөн улсын цолтон олноороо төрөх болов уу. Бөхчүүдийн хувьд маш олон боломж байгаа учраас дөрвөн жил бэлтгэлээ сайтар хангасан залуу бөхчүүд цолоо ахиулахаар барилдана. Тиймээс тун өрсөлдөөнтэй болох байх. Урьд нь 512 бөх барилдаж, есийн даваатай байсан бол энэ жил тэгш ой тохиож буй учир 1024 бөх барилдаж, 10 даваатай болсон. Улсын арслан цолтой бөх үзүүрлэсэн тохиолдолд шууд аварга болох боломжтой. Ер нь энэ жил маш өрсөлдөөнтэй наадам болох болов уу.

-Монгол хүүхдүүд багаасаа л барилдаж өссөн байдаг. Таны хувьд хэдэн наснаасаа Үндэсний бөхийг сонирхож эхлэв?
-Монгол хүүхдүүдийн нэгэн



ОЮУНЛАГ БАГАЧУУД

Ц Э Ц Э Р Л Э Г

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАНД УРЬЖ БАЙНА

Байгууллагын зорилт, чиг үүргийг мэргэжил, мэргэшлийн өндөр түвшинд хэрэгжүүлэх чадвартай удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ

Нийтлэг шаардлага:

Боловсрол: Боловсролын бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй

Мэргэжил: Сургуулийн өмнөх боловсролын багш

Мэргэшил: СӨБ, Боловсролын менежмент

Туршлага:

- Боловсролын байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан байх

- Багшлах болон боловсролын удирдлагаар хосолсон дадлага туршлагатай байх

- Боловсрол, удирдлагын чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх

Ур чадвар:

- Стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөлт хийх

- Англи хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй

- Мэдээлэл боловсруулах

- Асуудал шийдвэрлэх

- Судалгаа шинжилгээ хийх

- Компьютерийн хэрэглээний программуудыг ашиглах

- Бусдыг манлайлах

- Багаар ажиллах

- Ёс зүйн болон харилцааны соёлтой байх

АХЛАХ ТОГООЧ

Нийтлэг шаардлага:

Боловсрол: Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй

Мэргэжил: Хоол үйлдвэрлэл, хүнсний технологи болон

нийтийн хоолны технологич мэргэжлээр төгссөн

Мэргэшил: Нийтийн хоолны чиглэлээр мэргэшсэн

Туршлага:

- Сургууль болон цэцэрлэгт нийтийн (хүүхдийн) хоолны

чиглэлээр 5-аас доошгүй жил ажиллаж байсан

- Тогоочийн зэрэгтэй, ахлах тогооч болон тогоочоор

ажиллаж байсан туршлагатай байх

- Сургууль, цэцэрлэгийн тогооч нарын сургалтад

хамрагдсан байх

Ур чадвар:

- Бусадтай хамтран ажиллах чадвартай

- Бүтээлч сэтгэлгээтэй байх

- Компьютерийн хэрэглээний программуудыг ашиглах

- Бусдыг манлайлах

- Багаар ажиллах

- Ёс зүйн болон харилцааны соёлтой байх

Тусгай шаардлага:

Сургууль, цэцэрлэгийн хэв шинж онцлогийн талаар

зохиж мэдлэг, туршлагатай байх

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

1. Боловсролын дипломын нотариатаар баталгаажуулсан хуулбар

2. Иргэний үнэмлэхийн нотариатаар баталгаажуулсан хуулбар

3. Ажил байдлын тодорхойлолт

4. Хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн холбогдох

хэсгийн нотариатаар баталгаажуулсан хуулбар

5. 3x4 хэмжээтэй 2% зураг

6. Тухайн албан тушаалд томилогдох хүсэлт, өөрийн мэдлэг, ур

чадвараа илэрхийлсэн өргөдөл

7. Тухайн байгууллагыг хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөө, хөтөлбөр

8. Боловсрол, удирдлагын чиглэлээр мэргэшүүлэх сургалтад

хамрагдсаныг нотлох диплом, сертификатын баталгаажуулсан

хуулбар эсвэл эх хувь

Жич: Тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангаагүй болон

холбогдох материалыг дутуу бүрдүүлсэн иргэнийг бүртгэхгүй.

Хаяг: Улаанбаатар хот, Хан-уул дүүрэг, 11-р хороо, Их монгол

улсын гудамж, "Deluxe marshall village" хотхон, King tower

apartment 1-4 байрны Lobby танхимд

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

70 жилийн түүхт "АЛДАР"-ЫНХАН энэ наадамд өнгөтэй байна

адил хар багаасаа дээлээ урж, ноцолдож өссөн дөө. Өсвөр насандаа самбо бөхийн дугуйланд орж хичээллэсэн хойш самбо, жудо бөхөөр олон жил барилдсан. Харин 20 гарсан хойноо Үндэсний бөхөөр хичээллэж эхэлсэн юм. Ер нь 13, 14 настайдаа барилдаж эхэлснээс хойш эдүгээр хүртэл бөхөө хаяагүй л явна.

-Самбо бөхийн дугуйланд хэн нэгэн таныг урьж байв уу, эсвэл өөрийн сонирхлоор хичээллэж эхэлсэн үү?

-Социализмын үед дэлхийн аваргууд бүгд л самбо бөхөөр барилддаг байсан юм. Бүх спортын номер нэг нь самбо бөхийн барилдаан байлаа. Одоо бол жудо болчихжээ. Тухайн үед дэлхийн

-Шавь нар тань амжилт гаргахад сайхан байдаг байх даа?

-Шавь нар чинь сүүлдээ үр хүүхдээс ялгаагүй болчихдог юм байна. Үр хүүхдээ амжилт гаргахад хүмүүс яаж баярладаг билээ. Яг түүн шиг л баярладаг.

-Бөхчүүдийн хувьд анхны даваа нь мартагддаггүй юм гэсэн. Та анхны давааныхаа дурсамжаас бидэнд хуваалцаач?

-20 гаруй насандаа Үндэсний бөх рүү орсон гэж дээр дурьдсан шүү дээ. Хотод ирснийхээ дараа заалны барилдаанд цэргийн начин Д.Отгон гэдэг хүнээр анх удаа давж байсан юм. Анх барилдаж байсан би аймгийн арслан цолтой

суудалдаа тухлав. Наадамд зодоглох бөхчүүдээ эргэж, өнгө зүснийг нь шинжихээр ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Даваа, Баглан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, хурандаа Б.Батсайхан тэргүүтэй БХЯ, ЗХЖШ-ын удирдлага, алба хаагчид, "Алдар" спорт хорооны дарга, хурандаа Г.Өсөхбаяр нар хүрэлцэн иржээ. Тэдний ирэхэд бүх л тамирчид эгнэн зогсч мөндэлсний зэрэгцээ Д.Даваа генерал ч бүгдтэй нь гар барин мөндчилж амжилт хүсч байлаа. Дараа нь тэд хүндэтгэлийн суудалдаа сууж, бэсрэг наадмын хүчит 32 бөхийн барилдаан эхлэв. Бэсрэг наадамд үндсэн галын бөхчүүдээс гадна Архангай,

хүний бүрэлдэхүүнтэй байдаг юм. Хавраас гадаа бэлтгэлээ хийж, зунжин тэмцээн уралдаанд оролцоод намар хаалтын тэмцээнээ дуусгадаг бид бусад багуудаас ялгарах онцлогтэй. Тодруулбал, бид өвөл зааландаа бэлтгэл хийдэг. Нэг үгээр жилийн дөрвөн улиралд бэлтгэлтэй байдаг юм. Биднийг бэлтгэл хийх бүхий нөхцөл бололцоогоор спорт хороо хангаж өгдөг. Үүгээрээ ч их бахархдаг юм" хэмээн хошой аварга маань ярьж байна. Тиймдээ ч "Алдар"-ын сурын харваачид жил жилийн наадамд том амжилттайгаар оролцдог биз. Өнгөрсөн жил гэхэд Буриад, Халх сурын харвааны түрүүт зөвхөн "Алдар" спорт хорооны

дунд Ахмадын Үндэсний сурын харвааны улсын аваргын тэмцээн зохион байгуулагдсан юм.

-Энэ жил шинээр улсын мэргэн төрөх болов уу?

-Төрөлгүй яах вэ. Хэн ч болж магадгүй. Хэн гэдгийг тааж хэлэхэд хэцүү. Мэргэчүүд цолоо ахиулж болно. Шинээр гарч ирж ч магадгүй. Сурын харваа хэцүү. Тухайн үед хэн азтай, одтой байна тэр хүн л түрүүлнэ шүү дээ.

-Үндэсний сурын харваа хүнээс тэсвэр тэвчээр их шаарддаг юм шиг санагддаг?

-Тийм шүү. Хүнээс маш их тэсвэр тэвчээр шаарддаг. Нарны өөдөөс хараад зогсоход тийм амар биш. Туйлын сонирхолтой, дуртай тулдаа л ингээд зогсч байна даа.

багш дээр сур харваж сурахаар очиж байлаа. Нэгдүгээр курсээсээ л эхлээд хичээллэсэн. Үндэсний сурын доктор, профессор спортын мастер, Үндэсний сурын холбооны хүндэт Ерөнхийлөгч мундаг багш бий. Багшийнхаа удирдлага дор их сургуулийн дөрвөн оюутны хамт хичээллэж эхэлсэн ч, эцэстээ ганцаараа торойгоод үлдсэн дээ.

-Анхны тэмцээний дурсамжаас сонирхуулбал?

-Эхлээд Үндэсний сурын нийгэмлэгүүдийн жижиг тэмцээнээс эхэлж байлаа. Сурын харваагаар хичээллэж эхэлснээс хойш нэг, хоёр жилийн дараа жижиг тэмцээнд түрүүлж, яг таван жилийн дараа улсын мэргэн



аварга болно гэсэн хүүхэд насны хүсэл мөрөөдөлдөө хөтлөгдөж самбо бөхөөр хичээллэж эхэлсэн. Яах вэ, тэр мөрөөдлөө ч биелүүлж, дэлхийн аваргын хүрэл медаль хүртсэн. Харин дараа нь Үндэсний бөхөөр хичээллэж аймгийн арслан болсныхоо дараа улсын цол хүртэж байлаа.

-Үндэсний бөхийн спорт руу сонирхлоороо л орчихсон уу?

-Тэгэлгүй яах вэ. Үндэсний бөх самбо, чөлөөт барилдааны үндсэн суурь нь байдаг юм. Ямар ч монгол хүүхэд Үндэсний бөхөөр барилдаж чаддаг. Энэ спортоор хичээллэхэд тэр авьяас нь илүүтэй хөгждөг юм. Тэр жишгээр жаахан хожуу ч гэхүү, 20 гаруй насандаа Үндэсний бөхөөрөө хичээллэж эхэлсэн дээ.

-Та удам дагаж бөх болов уу?

-Бөхийн удам бий. Миний ээжийн хоёр дүү аймгийн арслан Жамьянсүрэн, цэргийн заан Отгонбаатар гээд хүмүүс байдаг юм. Тэр талаа бодвол манай удамд сайн бөхчүүд бий. Дүү маань ч гэсэн сумандаа тав түрүүлсэн сумын заан хүн байдаг юм.

-Хүүтээ бөх болгоё, бөхийн спортод оруулья гэсэн бодол танд байдаг уу?

-Үндэсний бөх өөрөө мэргэжлийн спорт тал руугаа өндөр хөгжсөн. Ийм үед Үндэсний бөхөөр хүссэн хүн бүр амжилт гаргаж цол авна гэдэг нэлээд хүнд даваа шүү дээ. Миний хүү барилдвал сайн л байна. Барилдахгүй байсан ч яах вэ. Би ганц хүүтэй. Өөрийнхөө хүслээр барилдвал тэр л биз. Түүнээс биш шахахгүй. Хүн бүрийн чадвар өөр өөр. Тиймээс өөр өөрийнхөө хэмжээнд л сумын начин, заан гээд цол авдаг юм.

-Гарын шавь бий биз?

-Бий бий. Нэлээд олон байгаа. Шавь нар маань сайхан барилдаан үзүүлнэ гэдэгт итгэлтэй байгаа. Эхнээсээ улсын цол аваад эхэлчихлээ. Улсын начин Э.Даш миний шавь байгаа юм. Мөн Б.Серик, Н.Мустапа, Д.Анар гэх мэт аймгийн арслан, заан цолтой 10 гаруй шавьтай. Тэд маань энэ наадамд бүгдээрээ сайхан барилдаж, цолоо ахиулах байх.

өөрөөсөө том биетэй бөхийг давж байсан минь одоо ч санаанаас гардаггүй.

-Таны аав ямар хүн байв. Хүү нь бөх болоход баярлаж байсан байх?

-Намайг Үндэсний бөхөд хөтөлж оруулсан хүн бол миний аав байгаа юм. Их л баяртай байдаг байсан. Яах вэ намайг улсын начин болохыг үзсэн. Улсын начин цол хүртсэний намар аав минь өөд болсон.

-Бөхийн ёс жудаг сүүлийн үед гээгдээд байна уу даа гэх хардлага нийгэмд байдаг юм. Үндэсний бөхийн зүлэг ногоон дэвжээнд гараасаа олон шавь төрүүлсэн хүний хувьд та ямар бодолтой байдаг вэ?

-Олон хүнтэй харьцаж буй багш хүний хувьд энэ талаар заримдаа эргэцүүлэн боддог л юм. Аливаа юм хоёр талтай шүү дээ. Орчин үед хэвлэл мэдээлэл эрчимтэй хөгжсөнтэй холбоотойгоор жижиг зүйл том болж харагдах тал бий. Нөгөө талаар, монгол бөх ёс суртахуун, ёс жаг дээр үндэслэж барилддаг юм. Монгол наадам тэмцэл биш. Тэмцэл гэвэл тэмцээн болно. Наадам гэдэг баяр наадам шүү дээ. Сүүлийн үед тэмцэл гэх зүйл хүчтэй гарч ирсэн. Хүчтэй өрсөлдөөний уршаар бөхийн барилдааны гол үндэс болох ёс жудаг алдагдаад байх шиг. Үндэсний их баяр наадам бол тэмцэл биш, зүгээр л баяр. Хэт улайрч, тэмцэлдээд ирэхээрээ ёс жудаг уламдаа гишгэгдэх асуудал гарч ирж байгаа юм. Үнэхээр ч амь амдралаа золиослоод хүнд спорт руу орж байгаа учир аргагүй л байх. Аливаа юманд сайн тал байхад сул тал бас бий.

Ч.Санжаадамба
түрүүлж, Н.Мустапа
үзүүрлэв

Бид ийн хөөрөлдөж байх зуурт бэсрэг наадмын бэлтгэл ажил үндсэндээ шувтарч, Зэвсэгт хүчний Жанжин штабын удирдлагууд хүрэлцэн ирж, бөхийн барилдаан эхлэхэд бэлэн болсон байх нь тэр. Улсын начин Ш.Зоригт ч шүүгч хийхээр

Хөвсгөл аймгийн бөхийн галд бэлтгэлээ базааж буй бөхчүүд ч хүрэлцэн ирсэн байлаа. "Алдар" спорт хорооны бөхчүүдээс хэн хамгийн өнгөтэй байгааг харах гэж яарч байснаа ч нуугаад яах вэ. Ингээд бөхийн барилдаан ч эхэлж, эхний даваанаас 16 бөх үлдсэн юм. Цол зэрэгтэй, залуу бөхчүүдээс илүү бэлтгэлтэй, хэдэн жилийн наадамд илүү барилдсан гэдгээрээ аймаг, улсын цолтой бөхчүүд аргагүй ялгарч байна билээ. Эхний хоёр гурван даваа цай уух зуурт л болж өнгөрсөн бол шөвгийн дөрвөн бөхийн барилдаан тун чиг ширүүн өрнөсөн. Бэсрэг наадмын хүчит 32 бөхийн барилдааны шөвгийн дөрөвд Аймгийн арслан Н.Мустапа, Улсын заан Ч.Санжаадамба, цэргийн начин Б.Зоригтбаатар, аймгийн арслан М.Баяржавхлан нар шалгарч үлдсэн юм. Үзсэн олон ч эдгээр бөхчүүд өнгөтэй байгааг өөр хоорондоо ярьж буй харагдсан. Ингээд үзүүр түрүүнд тэднээс Н.Мустапа, Ч.Санжаадамба нар туван үлдэж, Ч.Санжаадамба түрүүлснээр бөхийн барилдаан өндөрлөлөө.

Д.Норжмаа мэргэн
сурын харваачдаа
ахалж байна

Бөхийн галаа эргэж, бэсрэг наадам зохион байгуулж яваа Зэвсэгт хүчний Жанжин штабынхан Үндэсний сурын харваачдынхаа цэц мэргэнийг ч сорилоо. Ерөнхийдөө "Алдар" спорт хорооны Үндэсний сурын харваачдыг Д.Норжмаа мэргэн ахалж, бэлтгэл сургуулилыг хийлгэж буй аж. Гэхдээ энэ удаа Д.Норжмаа мэргэн ирээгүй байсан тул гэр бүлээрээ үндэсний сурын спортод амьдралаа зориулж яваа улсын хошой мэргэн С.Энхтунгалагт бид уулзлаа. Тэрбээр "Алдар спорт хорооны Үндэсний сурын харвааны баг Монголдоо ганц мэргэжлийнх гэж хэлэх би дуртай. Цэргийн цол зэрэгтэй, цалинтай сураа харваад явж байдаг тамирчид нэлээд олон бий. Мөн зэрэг цолгүй спортын мастер, дэд мастер гэсэн 20 гаруй

тамирчид л хүртсэн байдаг. Бүр тодруулбал, таван хүн айрагдсан амжилттай байсныг уншигчид санаж буй болов уу. Энэ амжилт ямар мундаг харваачид "Алдар"-аар овоглож явдгийн тод жишээ юм. С.Энхтунгалаг мэргэний хэлж буйгаар сүүлийн жилүүдэд бага улам сайжруулах зорилгоор шинэ залуу харваачдыг эгнээндээ нэгтгэх болжээ. Залуу тамирчдаа зэрэг, цолд хүргэхийн төлөө сургаж, бэлтгэсний үр дүн нь ч гарч эхэлсэн гэнэ. Тухайлбал, сурын харваагаар жил гаруй хугацаанд суралцсан Жаргалсайхан спортын дэд мастер цол авсан бол Баян-Өлгий аймгаас зорьж ирэн сургуулилт хийсэн арваннэгдүгээр ангийн сурагч Х.Цогбаяр хүү Өсвөрийн улсын аварга болжээ. Мөн Д.Норжмаа мэргэний хүү улсын нээлттэй тэмцээнд гуравдугаар байрт шалгарсан байна. Энэ мэтээр "Алдар"-ын залуу үе өнгөтэй явна. Бөхийн галд зочлох далмаар бэсрэг наадам үзэж, гэр бүлийн улсын мэргэнтэй таарсандаа бид ч баяртай явлаа. Энэ зуурт улсын хошой мэргэн С.Энхтунгалагаас хэдэн асуултад хариулт авсан юм.

С.Энхтунгалаг: Шинэ
цолонд хүрсэн юм чинь
үзэлцэнэ ээ

/Улсын хошой мэргэн/

-Наадамд цэц мэргэнээ сорих харваачдын өнгө ямаршуу байна?

-Энэ жил харваачид маань өнгөтэй байгаа. Б.Баярсайхан мэргэн, Д.Норжмаа мэргэн их өнгөтэй байна даа.

-"Алдар" спорт хороонд хэчнээн улсын мэргэн байдаг вэ?

-Дөрөв бий. Хоёр эрэгтэй, хоёр эмэгтэй байгаа.

-Өнгөрсөн жил танай гэр бүлийн хүн ч гэсэн түрүүлж байсан байх аа?

-Тийм ээ. Хамт түрүүлсэн. Саяхан Ахмадын улсын аварга шалгаруулах Үндэсний сурын харвааны тэмцээнд нөхөр маань түрүүлсэн. Эрэгтэй 60, эмэгтэй 55-аас дээш насны харваачдын

-Та энэ спортоор хэзээнээс хичээллэж эхэлсэн бэ?

-1981 оноос хойш Үндэсний сурын харваагаар хичээллэж эхэлсэн. Эдүгээ 35 жил дахь жилтэйгээ золгосон байна. Анх 1986 онд түрүүлж байлаа. Түүнээс хойш 29 жилийн дараа өнгөрсөн жил хошой мэргэн болсон. Шинэ цолонд хүрсэн юм чинь энэ жилийн наадмаар үзэлцэнэ л гэж бодож байгаа. Сая Үндэсний сурын Улсын аварга шалгаруулах тэмцээнд хоёрдугаар байрт шалгарсан.

-Хошой мэргэнээс дараагийн зэрэг цол нь юу байна?

-Гоц мэргэн, гарамгай мэргэн гээд хязгааргүй шүү. Зургаа түрүүлсэн гавьяат Ч.Мөнхцэцэг дархан мэргэн цолтой. Түүний дараа тав түрүүлсэн даяар дуурсах мэргэн Х.Даваажаргал, дөрвө түрүүлсэн гарамгай мэргэн Х.Оюунцэцэг гээд олон мундаг эмэгтэйчүүд бий. Энэ мэтээр том том мэргэнүүд тус тусдаа бэлтгэлээ базааж байна.

-Энэ жилийн наадмын Үндэсний сурын харваа ямар онцлогтой байх бол?

-Энэ жил харваачид их болсон болохоор наадмын талбайд багтахгүй гээд тооны хязгаар тогтоочихсон. Талбай руу 500-аас илүү харваач оруулахгүй гэнэ билээ. Үүнээс гадна шинэ залуу харваачдад босго тавьчихсан байгаа. Наадмаас өмнөх улсын тэмцээнд 20 оноогүй бол улсын зэрэг цолгүй, шинээр орж ирсэн залуучуудыг наадамд оролцуулахгүй болсон.

-Таны хүүхдүүд ч гэсэн Үндэсний сурын харваагаар хичээллэж байсан гэж сонссон юм байна?

-Хоёр хүү маань сур харвадаг. Гэхдээ одоо завгүй болцгоосон. Арваннэгдүгээр анги төгсөж сур харваж байсан юм. Оюутан болж, их сургууль төгссөнийхөө дараа төрийн албанд орсноос хойш хоёулаа завгүй болсон.

-Хамгийн анх сурын харваа гэх тэвчээрийн спорт руу татагдаж орсон түүхээсээ манай уншигчдад хуваалцаач?

болж байсан юм.

-Үндэсний сурын харваачид ихэнхдээ удам дагасан байх нь бий. Харин таны хувьд?

-Манай удамд харваач байгаагүй. Харваачид ихэнхдээ ээж аав эмээ өвөөгөөсөө уламжилсан байдаг. Харин би дундаасаа орчихсон юм. Өөрөө харваж эхэлснээс хойш ханиа, хоёр хүүгээ, найз нөхдөө ч энэ спорт руу оруулсан даа. Хэд хэдэн шавь бий.

-Тамирчдад бие махбодийн бэлтгэлээс гадна сэтгэлзүйн бэлтгэл их чухал юм шиг санагддаг?

-Сэтгэлзүйн бэлтгэл хамгийн чухал. Өвөл, зун, хавар, намартаа нум сумтайгаа сайтар танилцсаны дараа сэтгэлзүйн бэлтгэл хийх хамгийн чухал. Сэтгэлзүйгээ зөв удирдаж, биеэ зөв удирдаж чадсан хүн л байгаа оноо.

...Биднийг ийн ярилцах зуурт нар хэдийнэ жаргах дөхжээ. Хэдхэн хоногийн дараа болох Үндэсний их баяр наадамд амжилттай оролцох ерөөл тавьж бид ярилцлагаа төгсгөлөө. Монголчууд бидний итгэл найдвар түүлэлгэж, түрүү бөх, мэргэний хүлээлт арь хэдийнэ багтаасан тамирчид бэлтгэлээ ийн базааж байна. Байгалийн сайханд саагаж, бөхийн уран мэх, харваачдын цэц мэргэнийг үзэж сонирхсон манай сурвалжлагч багч нийслэл хотын зүг төмөр хүлгийн жолоо залахад бэлэн болсон байлаа. Дэлхийн хоёрдугаар дайны гашуун сургамж, хар сүүдэр бүрэн арилж амжаагүй байх үе буюу 1946 оны хоёрдугаар сарын 2-ны өдөр манай ард түмэн анхны дөрвөн спортын нийгэмлэгийг байгуулсны нэг нь тухайн үеийн "Цэрэг" нийгэмлэг буюу өнөөгийн "Алдар" биений тамир, спортын хороо байсан түүхтэй. Байгуулагдсан цагаас өнөөг хүртлэх хугацаанд Монголын мянга мянган залуус, цэрэг эрсийн бие бялдар, өв тэгш хүмүүжлийг хангахын зэрэгцээ Монгол Улс, Зэвсэгт хүчний нэр хүндийг олон улс, тив, дэлхий, олимпын тавцанд өргөн мандуулсаар байгаа "Алдар" спорт хорооны сургалтын баазад нэг өдөр саатсан сурвалжлагаа энэ хүргээд өндөрлөө.

ДЭЛХИЙ

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДЫН АНХААРАЛД

Доорх жагсаалтад нэр дурдсан тусгай зөвшөөрөл эзэмшигчид Та бүхэн хүснэгтэд заасан хугацаанд Ашигт малтмалын тухай хуулийн 32 дугаар зүйл болон 34 дүгээр зүйлийн 34.4-д заасны дагуу төлбөрөө хугацаанд нь бүрэн төлж бүртгүүлэхийг мэдэгдье.

№	Код	Эзэмшигч	Талбай (га)	Олгосон огноо
1	MV-017564	Жөн Юан	478.62	2014.07.02
2	MV-013858	Монкварц	140.11	2004.07.02
3	XV-012524	Горняк	2630.38	2007.07.02
4	XV-007856	Зараяа холдингс	11692.43	2004.07.02
5	MV-001824	Дархан молор-Эрдэнэ	44.86	1999.08.25
6	XV-018685	Монгол таавар	7439.52	2015.07.02
7	XV-018664	Цагаантамич	185.74	2015.07.02
8	MV-018972	Ди Би Эс Ти ресорсис	3667.04	2015.07.02
9	XV-018571	Шунхатбаян	1033.27	2015.07.02
10	XV-017142	Алтандорнод монгол	3581.18	2007.07.03
11	XV-014979	Хотгоршанага	204.97	2009.07.03
12	MV-017568	Коол Адвентурс	960.35	2014.07.03
13	MV-006005	Эрдэсхолдинг	39.09	2003.07.03
14	XV-017138	Алтандорнод монгол	2753.68	2007.07.03
15	MV-017566	Тэвхэн	11.05	2014.07.03
16	MV-016868	Онолтмөнх	101.39	2011.07.04
17	MV-013852	Эрдэнэресурс Монголиа	335.02	2008.07.04
18	MV-017352	Гео-Эрин	124.2	2013.07.04
19	MV-017156	Бумбат	46.13	2004.07.06
20	XV-007875	Эрдэсхолдинг	1653.66	2004.07.06
21	MV-017350	Цахирцагаан гол	231.77	2013.07.05
22	XV-012532	Бэрхресорсиз	10550.97	2007.07.05
23	MV-017157	Бумбат	39.67	2004.07.06
24	XV-012536	Эф Эм Ай	5039.21	2007.07.05
25	MV-016871	Занадукоал монголиа	6124.37	2011.07.06
26	XV-018799	Эй Би Пи Девелопмент	2284.47	2015.07.07
27	XV-013472	Мөнгөнхас шонхор	515.05	2008.04.07
28	XV-014982	Эрэнскай	5076.13	2009.07.07
29	XV-018824	Талын Монгол Групп	3019.6	2015.07.07
30	MV-018994	Дарханговь	41.53	2015.07.07
31	XV-018838	Талын Монгол Групп	150.49	2015.07.07
32	XV-018836	Талын Монгол Групп	402.63	2015.07.07
33	XV-018702	Универсал говь майнинг	14074.88	2015.07.07
34	XV-017561	Эрэнскай	1975.82	2009.07.07
35	MV-017073	Терра майнинг	5053.69	2012.07.07
36	XV-017562	Эрэнскай	1685.51	2009.07.07
37	MV-010126	Чандганакоул	31.98	2005.07.08
38	XV-018655	Ү-Мён	1702.83	2015.07.08
39	MV-014987	Хулдын нүүрс	1423.81	2009.07.08
40	MV-007902	ДБТХ	254.79	2004.07.08
41	MV-003506	Их уулын эрдэнэс	29.29	2001.07.09
42	MV-017570	Могол интэрнэшл	14465.1	2014.07.09
43	MV-013869	Батгөр гэрэл	163.24	2008.07.09
44	XV-020557	Хүннү говь алтай	542.66	2005.07.09
45	XV-020558	Хүннү говь алтай	318.53	2005.07.09
46	MV-013331	Барилга-Орд	29.01	1995.07.09
47	MV-014992	Монресорсиз	1789.37	2009.07.09
48	XV-013871	Кожеговь	20627.53	2008.07.09
49	MV-003508	Хотгоршанага	814.5	2001.07.09
50	MV-017572	Могол интэрнэшл	182.78	2014.07.09
51	MV-004646	Монголианминералз питин	32.97	2002.07.09
52	MV-017349	Модурресурсэс	2497.04	2013.07.09
53	MV-017066	Немон-Инженеринг	40.07	2008.07.09
54	MV-005507	Дархан алтан туул	31.97	1995.07.09
55	MV-017575	Коммонмакс	6129.84	2014.07.10
56	MV-016877	Ариунхайрхан	27.09	2011.07.10
57	MV-020442	Батбродерс	1500.51	2000.07.10
58	MV-016876	БТМГ	37.23	2011.07.10
59	MV-016880	ЭСТО	56.23	2011.07.10
60	XV-018908	Геоталст	3493.57	2015.07.10
61	MV-004659	Идэрхайрхан	31.84	2002.07.10
62	XV-018730	Талын Монгол Групп	337.19	2015.07.10
63	XV-017823	Гурван оч констракшн	12385.06	2015.07.10
64	XV-018728	Талын Монгол Групп	908.86	2015.07.10
65	XV-018731	Талын Монгол Групп	83.1	2015.07.10
66	XV-018786	Нэгүүндринг	3192.93	2015.07.10
67	XV-018674	Эм Би Би Си	70.25	2015.07.10
68	XV-018673	Ноёхонзагас	448.8	2015.07.10

69	MV-003512	Бүүргэнт	45.1	2001.07.10
70	MV-002426	Монголгазар	373.59	2000.07.10
71	MV-002427	Монголгазар	173.11	2000.07.10
72	XV-018904	Эс Өү Би Би Ти майнинг	3658.78	2015.07.10
73	MV-013875	Монлаа	275.63	2008.07.10
74	MV-011860	Дацантрейд	39.12	2006.07.14
75	MV-007929	ЖЕМИ интэрнэшл	26.45	2004.07.14
76	MV-015620	Би Жи Эм Би	183.75	2010.07.14
77	MV-015646	Моручи	56.95	2010.07.15
78	XV-007941	Адамасмаунтин	5165.66	2004.07.16
79	XV-014995	АХХ	15136.11	2009.07.16
80	MV-001747	Чылагу	26.52	1999.07.16
81	XV-013879	Би Ди Би Эл	2219.51	2008.07.16
82	MV-017577	Би Вай Эйч	1966.16	2014.07.16
83	MV-003518	Новодин	29.21	2001.07.16
84	MV-017579	Юниверсалкоппер	5300.54	2014.07.17
85	XV-012556	Өсөххүч	50.46	2007.07.17
86	MV-013882	Минжит булган гол	32.91	2008.07.17
87	MV-012549	Дарханшар бүрд	49.86	2007.07.17
88	MV-011864	Каверболд	841.13	2006.07.17
89	MV-017078	И Си Эм	5985.46	2012.07.17
90	MV-017076	Төв азийн гантиг	75.89	2012.07.17
91	MV-011863	Кайнарвольфрам	633.15	2006.07.17
92	MV-017077	Тайширын хүдэр	1097.4	2012.07.17
93	XV-013893	Интраговь гоулд	10477.05	2008.07.18
94	XV-013896	ВАБК	197.03	2008.07.18
95	XV-013897	Есон цагаан гэр	14156.79	2008.07.18
96	XV-013901	Цахирцагаан гол	1283.75	2008.07.18
97	MV-012558	Хэлтрэгэ	26.41	2007.07.18
98	MV-000203	Уулсноён	21.74	1995.07.19
99	MV-004663	Бритишмайнинг	235.57	2002.07.19
100	MV-001755	ЭБЭ	132.1	1999.07.19
101	XV-018929	Талын Монгол Групп	941.83	2015.07.20
102	XV-018139	Чингис Энержи Групп	14662.33	2015.07.20
103	MV-015282	Олон-Овоот гоулд	483.57	2009.07.20
104	MV-017080	Нижмөрөн	731.27	2012.07.20
105	XV-018907	Талын Монгол Групп	3661.1	2015.07.20
106	XV-018902	Эхнуурын эрдэнэс	1341.41	2015.07.20
107	XV-012562	Жну куанг инвестмент лимитед	55.48	2007.07.20
108	MV-000283	Илтгоулд	8.67	1996.07.20
109	MV-017084	Эмэмарай	143.1	2012.07.20
110	MV-017081	Нижмөрөн	346.75	2012.07.20
111	XV-018901	Төгөлдөр майнинг	4007.23	2015.07.20
112	MV-015283	Олон-Овоот гоулд	203.18	2009.07.20
113	XV-015006	Эй Эс Ти Эс	1894.31	2009.07.20
114	XV-015007	Сансар сүлжээ	19631.8	2009.07.20
115	XV-015000	Надмин	22307.11	2009.07.20
116	XV-018766	Хаанбуурынх	1547.8	2015.07.21
117	XV-020560	Монзол	76.2	2005.07.21
118	MV-007969	Морьтхангай	202.71	2004.07.21
119	XV-018448	Юү И Ар Ти Си Эф Жи	159.01	2015.07.21
120	MV-000704	Алтандорнод монгол	369.47	1997.07.21
121	MV-002449	Чандмань Эрдэс	203.15	2000.07.21
122	XV-010177	Монзол	329.51	2005.07.21
123	XV-018797	Терра-Энержи	3187.24	2015.07.21
124	XV-018802	Терра-Энержи	5006.83	2015.07.21
125	XV-018697	Будресорс	4850.05	2015.07.21
126	MV-013904	Бүржит корпораци	334.13	2008.07.21
127	MV-010172	Днаарх	24.05	2005.07.21
128	MV-000360	Эрэл	104.91	1996.07.22
129	MV-000200	Алтандорнод монгол	22.65	1996.07.22
130	MV-000015	Монголболгаргео	86.57	1996.07.22
131	MV-000288	Талстгөлтгөнө	56.09	1996.07.22
132	MV-001400	Сентеррагоулд монголиа	17.33	1995.07.22
133	XV-013905	Интраговь гоулд	23258.74	2008.07.22
134	XV-013912	Кожеговь	48117.69	2008.07.22
135	XV-013910	Кожеговь	6517.34	2008.07.22
136	MV-006066	Вэнчөн	74.6	2003.07.22
137	MV-000290	Баянгол эко заамар	518.7	1996.07.22
138	XV-013911	Кожеговь	25708.51	2008.07.22
139	XV-013907	Кожеговь	43852.26	2008.07.22
140	XV-013908	Кожеговь	38349.96	2008.07.22
141	MV-001401	Сентеррагоулд монголиа	8.92	1995.07.22

142	XV-013914	Талын элч	13074.34	2008.07.23
143	MV-001774	Эрэл	103.08	1999.07.23
144	XV-013915	Есонбаялаг	172.32	2008.07.23
145	MV-007976	Эрдэнийн хөгжил	30.74	2004.07.23
146	MV-007978	Хурай	232.1	2004.07.23
147	MV-015631	Хотгор минералс	2036.63	2010.07.23
148	MV-015633	Шаргалболор	164.29	2010.07.23
149	MV-015023	Хулд химикалс	991.03	2009.07.23
150	XV-016939	Талын элч	9396.35	2008.07.23
151	MV-000129	Алтандорнод монгол	103.76	1996.07.24
152	XV-015029	Монголстандарт	1112.09	2009.07.24
153	MV-016848	Монфрукт	130.36	2011.06.15
154	MV-015025	Зүбгол	95.64	2009.07.24
155	MV-016809	ЖБЦБ	31.12	2009.07.24
156	MV-012578	Дарханфлюорит	65.05	2007.07.25
157	MV-012579	Тээлийн шонхор	26.75	2007.07.25
158	MV-013927	Азаргын гол чоног	407.55	2008.07.25
159	MV-016891	Газархэвлий	143.17	2011.07.25
160	XV-017552	Дорнын чулуулаг	930.52	2007.07.25
161	MV-016889	Ханшижир	662.79	2011.07.25
162	XV-012576	Хусмод	29.52	2007.07.25
163	XV-012574	Дорнын чулуулаг	1627.93	2007.07.25
164	MV-010194	Аудяргео	143.46	2005.07.26
165	MV-010207	Лут чулуу	108.71	2005.07.26
166	MV-017088	Цагаан чулуут эллоис	965.41	2012.07.26
167	MV-010206	Лут чулуу	83.76	2005.07.26
168	XV-008018	Брэйвхарт ресорсиз	1228.32	2004.07.27
169	XV-008020	Тэнгэрийн гэгээн тал	238.76	2004.07.27
170	XV-018365	Элчит минералс	235.32	2015.07.27
171	XV-018096	Лугайрөүд констракшн	7679.8	2015.07.27
172	MV-017559	Айваору	166.7	2009.07.27
173	MV-019018	Мэжинбридж	505.45	2015.07.27
174	XV-018912	Хэмжээшгүй-Орд	5630.68	2015.07.27
175	XV-013936	Хосбогд	1594.16	2008.07.28
176	MV-001781	Монголиаголд корпорэйшн	153.41	1999.07.28
177	MV-019022	Угалзанцамхаг	43.32	1998.07.28
178	MV-017580	Юниверсалминерал эксплоерэйшн	1399.32	2014.07.28
179	XV-013930	Фэско	351.99	2008.07.28
180	XV-015035	Говьтулалга	164.44	2009.07.28
181	MV-010225	РЕМАР	73.76	2005.07.28
182	XV-013934	Дасмондрилл	3468.07	2008.07.28
183	MV-010219	Баялагбогд	243.22	2005.07.28
184	XV-013939	Кратон	7437.21	2008.07.28
185	XV-013938	Си Эм Си Эм	1864.73	2008.07.28
186	XV-015034	Говьтулалга	1223.98	2009.07.28
187	XV-013941	Кратон	740.2	2008.07.28
1				

ЧУХАЛ ХҮН

ДААТГАЛД ХАМРАГДААГҮЙ УНААЧ ХҮҮХДҮҮДИЙГ МОРЬ УНУУЛАХГҮЙ

Ц.СОЛОНГО

Үндэсний баяр наадам ойртож байгаатай холбоотойгоор Үндэсний баяр наадмыг зохион байгуулах хорооны Хурдан морины салбар хороо болон “Хүүхдийн төлөө үндэсний газар”-ын төлөөлөгч нар хуралдаж, унаач хүүхдийн аюулгүй байдал бөгөөд хурдан морины уралдааны хөтөлбөрийг танилцуулж, мэдээлэл хийлээ. Энэ үеэр ХХААЯ-ны Бодлого хэрэгжүүлэлтийн газрын мэргэжилтэн н.Бямбадоржоос зарим зүйлийг тодрууллаа.

-Хурдан морьдын уралдааны хөтөлбөр гарсан байх. Хэдэн хэдний өдөр ямар насны морь уралдах вэ?

Үндэсний их баяр наадмын хуулийн эрх үүргийн дагуу хурдан морины уралдааны хөтөлбөрт долдугаар сарын 10-ны өдөр хязгаал, шүдлэн 11-нд азарга, их насны морь, 12-нд соёлон, даага гэсэн зургаан насны ангилалаар уралдуулна. Харин 13-ны өдөр шинэ монгол адуу буюу бидний нэрлэж заншсанаар эрлийз морьдыг дээд, дунд, бага гэсэн насны ангилалаар уралдуулахаар хөтөлбөр гарсан байгаа. Морьдын уралдааны үеэр наадамч олондоо үзүүлэх хөтөлбөрийн хүрээнд Хүй долоо хутагт 13-ны өдөр Жороо морьдын тойргийн уралдааныг зохион байгуулна. Мөн 10, 11, 12, 13-ны өдрүүдэд морьд уралдах зурхай руу явж байх хооронд наадамчиддаа зориулж “Морьтоны гайхамшиг” тоглолтыг зохион байгуулахаар төлөвлөсөн. Хурдан морьдыг нас насны ангилалаар зохих зайд уралдуулна. Азарга, соёлон насны морьдыг 23, их насны морьдыг 25, хязгаалан насны морьдыг 18, шүдлэн насны морьдыг 14, даагыг 11 км зайд уралдуулна. Морь уралдаж байх явцад хэвлэл мэдээллийн хэрэгслийн тав, эмнэлэг, мал эмнэлгийн нэг, морь тайлбарлагчийн машинууд дагаж явна. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн таван машиныг “Хурдан морины салбар хороо”-ноос гаргаж өгнө.

-Унаач хүүхдийн унаж бэртэх тохиолдол гарах магадлалтай байдаг. Тийм болохоор эмнэлгийн байгууллага өргөн бүрэлдэхүүнтэй ажиллах байх?

Унаач хүүхдүүдийг дагаж эмнэлгийн машин явна. Эмнэлгийн машин дотор Хүүхдийн төлөө үндэсний газрын ажилтан хамт явахар болсон байна. Хурдан морины унаач хүүхдийн аюулгүй байдлыг хангах үүднээс “Хүүхдийн төлөө үндэсний газар”-аас 30 гаруй хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллана. Хүүхдийн

насны ангилалын асуудал болон хамгаалалтын хувцасны чанарын стандарт, эрүүл мэндийн даатгалын талаарх асуудлыг урьд жилүүдийнхээс илүү сайн хянан шалгаж ажиллахаар бэлтгэл ажил бүрэн хангагдаж дуусч байгаа.

-Тавиач хүүхэд унаж бэртэх тал дээр анхаарал хэр анхаарал хандуулж байна?

-Наадам болон морины комисс энэ тал дээр онцгой анхаарахаар ярилцаж байгаа. Өнгөрсөн жил 20 гаруй ажилтан байсан бол энэ жил 30 гаруй болгож нэмсэн. Нэмэгдсэн 10 гаруй ажилтан зөвхөн тавиач хүүхдүүдэд анхаарч ажиллана.

-Унаач хүүхдүүдийн аюулгүй байдлыг яаж хангаж ажиллах вэ?

Хурдан морины салбар хороо мориныг будилаангүй уралдуулах, ялангуяа унаач хүүхдүүдийн хувцасны стандартыг маш сайн анхаарч ажиллана. Малгай, цээживч, өвдгөвч, тохойвчтой хамгаалалтын хувцастайгаас гадна эмээлтэй унана гэсэн стандарттай байгаа. Энэ стандартыг баримталж ажиллана. Унаач хүүхэд, уяач, эцэг эх, хүүхдийн байгууллага гэрээ хийж ажиллана. Морь унаж байгаа хүүхэд заавал даатгалтай байх ёстой, даатгалгүй, хувцасны стандарт хангаагүй хүүхдийг морь унуулахгүй.

-Монгол морьд, эрлийз морьдыг уралдуулах журмын талаар?

-Үндэсний баяр наадмын

салбар хороо хуралдаад энэ жил монгол морьдыг эрлийз морьдоос ялгах журмыг ярилцаад, 05 тогтоолоор батлагдсан “Монгол морьдыг эрлийз морьдоос тусад нь уралдуулах журам”-ыг баримталж ажиллахаар бэлтгэл ажилдаа орсон.

-Монгол морьдоос эрлийз морьдыг яаж ялгах вэ?

-Морьдыг ялгахдаа морины ерөнхий биеийн галбир, сэрвээний өндрөөр ялгана. Ерөнхий биеийн галбир гэдэгт нь толгойн хэмжээ, хүзүүний суулт, дэл, сүүл зэрэг орно.

-Эрлийз морьдын биеийн галбир ямар байвал уралдаанд оролцуулах вэ?

-Эрлийз морьдыг сэрвээний өндрөөр нь эрлийз гэдгийг мэдэж болно. Азарга соёлон 140, их нас 141, хязгаалан 137, шүдлэн 132, даага 127 см өндөртэй байвал эрлийз морьдыг уралдуулна.

-Уралдааны морьдын бүртгэлийг яаж авах вэ?

-Морь бүртгэлийн хувьд нийт уяачиддаа анхааруулахад, баяр наадмын хөтөлбөрийн дагуу морьдоо цагт нь авчирч, сэрвээний өндрийг хэмжүүлж, үйлдвэрлэг байдлыг тогтоолгоно. Хугацаанаас хоцорсон, тэмдэглэлт хийлгээгүй морьдыг уралдуулахгүй гэж заасан. Сэрвээний өндрийг хэмжихдээ унаач хүүхдийг буулгаж байж хэмжих ёстой юм. Сэрвээний хэмжээ үйлдвэрлэг байдлыг хангаагүй бол тэнцэхгүй гэж үзнэ.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

НААДМААР ҮЕР ҮСНЫ АЮУЛААС БОЛГООМЖЛОХЫГ АНХААРУУЛЛАА

Хэдхэн хоногийн дараа Монгол түмний үндэсний их баяр наадам болох билээ. Цаг уурын хүрээлэнгийн урьдчилан мэдээлэх төвөөс ирүүлсэн мэдээллээр энэ сарын 6-9-нд нийт нутгаар халах төлөвтэй байгаа бөгөөд ялангуяа энэ сарын 8, 9-нд төв болон зүүн аймгийн нутгаар 33-38 хэт хүрч халах аж. Харин наадмын өдрүүдэд буюу 10-12-ны өдрүүдэд ихэнх нутгаар хур бороо үргэлжлэн орох юм байна. Тодруулбал, энэ сарын 9-нд баруун аймгийн нутаг, 10-нд төв хэсгээр, 11, 12-нд нутгийнхаа зүүн хэсгээр усархаг бороо орно. Тиймээс нийт ард иргэддээ наадмын өмнөх өдрүүдэд наршихаас, харин наадмаар үер усны аюулаас сонор сэрэмжтэй байхыг холбогдох байгууллагаас анхааруулж байна.

Нийт 24300 ам.метр талбайг зүлэгжүүлжээ

Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төвд өнгөрсөн сарын 27-ноос долдугаар сарын 04-ний өдрүүдэд нийт 92 санал, гомдол ирсэний дагуу шуурхай шийдвэрлэж ажиллалаа. Энэ хугацаанд төвлөрсөн хогийн цэгүүдэд нийт 2075 машинаар 20681.9 тонн хог хаягдал тээвэрлэж, устгасан байна. “Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл” ОНӨААТҮГ нийт 956 золбин нохой булж устгасан бөгөөд нийслэлийн Тээврийн газраас том оврын 5216 автобус, туслах шугамын автобус 415 тус тус гарч ажиллажээ. Ногоон байгууламжийн хүрээнд Нийслэл хүрээ өргөн чөлөөнд 40 ширхэг голтбор мод, Чингисийн өргөн чөлөөнд 2800 ширхэг, Соёлын төв өргөөнд 4000 ширхэг цэцэг тарьсан байна. Мөн Тасганы овооны голын зурвас, Чингисийн өргөн чөлөө, Их Монголын гудамж, Нисэхийн тойргын төгөл, Үйлдвэрчний Эвлэлийн гудамж, 7-н буудал, Хонхтой цэцэрлэг, нарны замын нийт 24300 ам.метр талбайг зүлэгжүүлжээ.

ЗАР ЗАР ЗАР

Ар-Гүнтийн зусланд модны дэргэд байрлалтай 8*10 хэмжээтэй дүнзэн торхтой зуслангын газрыг зарна.

Үнэ: 25 сая
Утас: 98989089

АСЕМ-ын залуучууд наадмын парадад алхана

Б.НОМИН

АСЕМ-ын дээд төвшний 11 дүгээр уулзалтын дагалдах хурлуудын нэг болох АСЕМ-ын Залуучуудын чуулган энэ сарын 6-10-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдах гэж байна. Дөрвөн өдрийн турш үргэлжлэх чуулга уулзалтад АСЕМ-ын гишүүн орны 3900 гаруй залуучууд бүртгүүлснээс зөвхөн 100 нь шилдгээр тодорч оролцохоор болжээ. Харин Монгол Улсын 300 гаруй залуусаас 50 нь шилдгээр тодорч, оролцогчоор бүртгүүлээд байгаа аж. Залуусын чуулганаар АСЕМ-ын гурван тулгуур болох улс төр, эдийн засаг нийгэм соёлын асуудлыг хэлэлцэх юм байна.

Хэлэлцэхдээ дипломат ёсны хүрээнд улс орон болгон өөрийн залууст тулгамдаж байгаа асуудлаар байр сууриа илэрхийлэх аж. АСЕМ-ын Залуучуудын чуулган хамгийн сүүлд 2014 онд Милан хотноо болж, Ази Европыг төлөөлсөн дөрвөн залуу чуулганаар хэлэлцсэн тунхаг бичгийг АСЕМ-ын дээд төвшний чуулганд танилцуулж байжээ. Энэ удаад ч мөн энэ жишгээр Ази Европыг төлөөлсөн дөрвөн залуу дээд төвшний уулзалтад оролцож, Европын талын төлөөлөл болсон залуу

хэлэлцсэн асуудлын тунхаг бичгийг танилцуулахаар болжээ. Гадны улсыг төлөөлөн ирж байгаа залуус Монгол дахь хөтөлбөрийг ихээхэн сонирхож байгаа тухай МЗХ-ны Удирдлага төлөвлөлт хамтын ажиллагааны газрын дарга Х.Ариунзүл ярилаа. Чуулганы нээлт энэ сарын 7-ны өдөр Улаанбаатар чуулгад болох аж. Нээлтийн үйл ажиллагаанд Ерөнхий сайд Ч.Сайханбилэг, МЗХ-ны ерөнхийлөгч, олон улсын байгууллага, элчин сайдын төлөөлөл, Монголын залуучууд зэрэг 400 гаруй хүн оролцох аж. Дараагийн хоёр өдөр загвар чуулганы жишгийн дагуу хэлэлцүүлэг явагдаж, гарсан тунхаг бичгийг нэгтгэн дээд төвшний уулзалтад илтгэхээр бэлтгэх юм байна.

Харин гурав дахь өдөр Цонжинболдогийн Чингис хааны хөшөөтэй танилцах бөгөөд дөрөв дэх өдөр буюу 11-ний өдөр гадны орны залуусын төлөөлөл болсон 25 залуу наадмын парадад алхахаар болжээ. Энэхүү чуулганы хамгийн анх 2004 онд Их сургуулийн оюутнуудын чуулга уулзалтаар Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан бол өдгөө улам өргөжиж 51 орны төлөөлөгчид оролцсон томоохон чуулга уулзалт болон өргөжсөн байна.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ



Зэвсэгт хүчний 027 дугаар анги буюу Батлан хатгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн халт олон өчигдөр шинэ цогцолбор барилгадаа орж, шинэ тоног төхөөрөмжтэйгөөр үйл ажиллагаагаа эхлүүлээ. Өнгөрөгч гурвдугаар сард тус эмнэлгийн шинэ цогцолбор барилгын нээлт болж байсан бол энэ удаа нэгдсэн эмнэлгийн халт олон шинээн байрандаа шинэ тоног төхөөрөмжүүдээ суурилуулан төвхнөж ажилдаа орсон байна. Ёслолын арга хэлжээнд Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, гадаад бодлогын асуудал хариуцсан зөвлөх А.Баттоф, ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Давсаа, Батлан хатгаалах яамны Стратегийн бодлого, төлөөлөлтийн газрын дарга, бригадын генерал Г.Сайханбаяр нарын албаны хүтүүс оролцоо.



Тэрэл зургийг Г.АРТҮҮЖИПН

Т.Цогт, Г.Маралмаа нарын шүүх хурал хойшиллоо

Х.ЦАЦРАЛ

Дөрвөн настай балчир охиноо онц хэрцгий аргаар зодож, улмаар үхэлд хүргэсэн гэх хэрэгт буруутгагдаж буй төрсөн эцэг Т.Цогт, хойд эх Г.Маралмаа нарыг шүүх хурал өчигдөр Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд болох байсан ч тодорхой шалтгааны улмаас хойшилжээ. Тодруулбал, шүүгчдэгч Г.Маралмаа өмгөөлөгчөөсөө татгалзсан учир ийнхүү шүүх хурлыг энэ сарын 27-ныг хүртэл дахин хойшлуулсан байна. Тэднийг шүүх хурал тавдугаар сарын 20-нд болох байсан ч, шүүгчдэгч өмгөөлөгч нэмж авах хүсэлт гаргасанаар хойшлуулсан байдаг. Улмаар Т.Цогтын шинэ өмгөөлөгч хавтаст хэрэгтэй танилцах шаардлагатай гэж үзсэн учраас энэ сарын 5-ыг хүртэл хойшлуулсан юм. Уг хэрэгт Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээс Эрүүгийн хуулийн 100 дугаар зүйлийн 100.1 дэх хэсэгт зааснаар 25 жилийн ял тус бүрт нь оноосон билээ. Гэхдээ 25 жилийн хорих ялаас хоёр жилийг өршөөж, тус бүр 23 жилийн хорих ял оноогоод байгаа билээ.

Наадмаар дугаарын хязгаарлалт үйлчлэхгүй

Үндэсний их баяр наадмын амралт долдугаар сарын 8-ны өдрөөс эхэлнэ. 10 хоног үргэлжлэх баярын амралтын үеэр нийслэл хотод автомашины дугаарын хязгаарлалт үйлчлэхгүй гэдгийг Замын цагдаагийн газраас мэдэгдэж байна. Наадамтай залгаад Улаанбаатар хотноо зохион байгуулагдах АСЕМ-тай холбоотойгоор автомашины хөдөлгөөнд зарим өөрчлөлт орж байгааг мөн мэдээлж байна. Тухайлбал, АСЕМ-ын дээд хэмжээний уулзалт болох долдугаар сарын 13-ны шөнийн 01.00 цагаас долдугаар сарын 16-ны 23.30 цагийн хооронд “Чингис хаан” Олон улсын нисэх буудал руу автомашинтай нэвтрэхийг хориглосон байна.

“U money” картын үйлдлийг нэмнэ

Нийслэлчүүд автобусаар “U money” картаар үйлчлүүлдэг болоод нэг жилийн нүүр үзэж байна. Иргэд уг картыг 2600 төгрөгөөр худалдаж аваад мөнгөн дүнгээрээ цэнэглэж хэрэглэдэг билээ. Одоогоор үүнээс өөр үйлдэл хийдэггүй. Тэгвэл цаашид автобусны картыг боловсронгуй болгохоор ажиллаж байгаа талаар нийслэлийн Тээврийн газраас мэдээллээ. Тухайлбал, зөвхөн автобусанд уншуулахаас гадна банкинд ашиглах зэргээр үйлдлийг нь нэмэгдүүлэхээр болжээ. Албаныхны мэдээлж буйгаар аль болох энэ сардаа багтаж үйлдлийг нь нэмж, төгөлдөржүүлэх гэнэ. Одоогоор нийслэлийн хэмжээнд 300 орчим цэгт иргэдийн картыг цэнэглэж үйлчилж байна. Автобусны эцсийн буудал, хүн их зорчдог газар, Зар мэдээ сонин худалдаалах цэг, Well-mart сүлжээ дэлгүүрүүдээр автобусны карт худалдах, цэнэглэх үйлчилгээ үзүүлж байгаа юм.

ЗАВСАРЛАГА

Нөлөөт толь



МАН-ынхан

одоо “ХАР” машинаас уучлал гуйгаарай

Н.ПУНЦАГБОЛД

Нэгэн цагт манай улс сонгуулийн саналаа гараар тоолж, тэгэх явцдаа хийж болох бүхнийг л хийдэг байсан. Харин 2012 он сонгуулиас эхлээд саналын хуудсыг автоматаар тоолдог болсон. Дэлхийн бүхий л улс орон технологийн дэвшил рүү явж байгаа энэ эрин үед манай орон ч гэсэн хоцрохгүй зэрэгцэж алхахыг хичээж байгаа нь энэ. Гэвч улстөрчид, зарим нэг намынхан санал тоолох машиныг ад үзэж, элдвээр хэлэх болсон. Хөөрхийг бүр “хар” хэмээн тодотгож, ад үзэж, хулгайч, луйварчин, саналын хуудсыг буруу тоолсон будилаанчин мэтээр хэлэх болсон. Хүн байсан бол гомдсондоо амна хорлохоор л хэмжээнд хүрч байлаа. Дуртай болгон нь санал тоолох машины нэр хүндэд халдаж, хулгайч хэмээн хардаж, “хар” хэмээн доромжлов. Бүр сүүлдээ нэр хүндэд нь халдаад зогсохгүй шатааж хүртэл үзэв. Гэхдээ санал тоолох машиныг биш л дээ. Дуурайлгаж хийсэн загварыг нь шатааж, гараар тоолох эртний үеэ дурсаж билээ, олон намууд.

Санал тоолох машины загварыг шатаасан тэр “кино”-ны гол дүрд МАН-ынхан тоглосон санагдаж байна.

Гэтэл 2016 оны ээлжит сонгуулиар дахиад л санал тоолох машинаар иргэдийн саналыг тоолов. Үр дүнд нь МАН үнэмлэхүй олонхи болж, энэ намаас нэр дэвшсэн эргүү тэнэг ч байсан сонгогдлоо. Ирэх дөрвөн жилд МАН-ын хэдэн шинэ гишүүн ажлаа хийж сурах гэсээр байтал дараагийн сонгууль болох байх. За тэр шинэ гишүүд ч яах вэ, угаасаа томчуудынхаа хэлснээр товчлуураа дараад сууж байна. Харин өнгөрсөн дөрвөн жил санал тоолох машиныг элдвээр хэлж, нэр төрд нь халдаж, бүр

шатааж хүртэл үзсэн МАН-ынхан одоо “хар” гэж тодотгоод байгаа машинаасаа уучлал гуйх цаг болсон.

Харин машин л луйварчин учраас бид ялагдсан. Тэгээгүй бол манай нам түүхэндээ цөөнх болох ёсгүй байсан юм гэх мэтээр яриад байсан биз дээ. Гэтэл өнөөх “хар” машин нь ямар үнэн ч болохоо харуулж, нэр төрөө цэвэрлэж авлаа. Эсвэл түрүүчийн сонгуулиар АН-д арай илүү суудал өгч, МАН-ын саналыг луйвардаад. Харин энэ удаад АН-д тун цөөхөн суудал өгч, МАН-ыг үнэмлэхүй олонх болгож луйвар хийгээгүй л бол шүү дээ. Тиймээс МАН-ынхан одоо уучлал гуйж, санал тоолох машины нэр хүндийг

дөрвөн жил унагасныхаа нөхөн төлбөрийг өгөх хэрэгтэй. Тэгээд “хар” гэж доромжилдог байдлаа одоо болимоор байна, хөөрхий. Дэлхий нийтээрээ арьс өнгөөр ялгаварлан гадуурхахын эсрэг байхад сонгогчдын саналыг чин шударгаар тоолж, хоёр ч сонгуулийн ард гарчихаад байгаа машинаа “хар” гэж доромжлох хэрэг юун. Цаашид “цагаан” машин гэж ярьдаггүй юм гэхэд ядаж “хар” гэхээ болимоор байна. Уг нь МАН-ынхан нэгэнт ялчихсан юм чинь санал тоолох машинд “но” алга байжээ гээд хэлчих юм болов уу гэж их харлаа. Өнөөдөр шинээр сонгогдсон парламентынхан анхдугаар чуулганаа хийж, гишүүд нь тангаргаа өргөсөн. Энэ үеэр МАН-ын зарим гишүүд уг хэлэхдээ санал тоолох машинаас уучлал гуйсангүй.

Улаанбаатарт:

Маргааш
Өдөр 33
Шөнө 19

Нөгөөдөр
Өдөр 34
Шөнө 20

Өдрийн зурхай

2016.07.06 / БИЛГИЙН ТООЛЛЫН 2


Зуны адаг хөхөгчин хонь сарын Есон улаан мэнгэтэй шарагчин үхэр өдөр



Аргын тооллын 7 сарын 6, Буд гараг. Билгийн тооллын 2, Найралт эх одтой, шарагчин үхэр өдөр. Өдрийн наран 5 цаг 03 минутад ландан, 20 цаг 48 минутад жаргана. Тухайн өдөр тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба логой, морь жилтнээ сөрөг туу нөлөөтэй тул элдэв үйлд хяналтай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адегуус туулах, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, мал арилжих, буг давах, газрын ал бооход сайн. Эрдэнийг гадагш өгөх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд туу. Өдрийн сайн цаг нь баг, туулай, логой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт төрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ТЭНГИС
КИНО ТЕАТР

Хүний амьдралын түүх бол зөвхөн хайрын түүх юм. Үзэсгэлэн төгс Үүлэнсолонго, баян эцгийн өв залгамжлагч Уран, бүгдийг зохицуулагч Содоо, нууцлаг бүсгүй Анна нарыг нэгтгэсэн зүйл нь юу вэ? Хайр хүний сэтгэлийн өөрчлөн эзэмддэг шигээ амьдрал хувь тавилан, нөхөрлөл, ирээдүйг ч бас өөрчлөж чаддаг. Бүгдийг гайхшируулах нэгэн ээдрээт тавилан, сэтгэл хөдөлгөм бодит түүхээс сэдэвлэсэн “Хөөрхөн шулам” кино таны хайрын тухай ойлголтыг өөрчлөх болно. Шулам төрдөггүй, шулмыг гарцаагүй амьдралын шаардлага бий болгодог юм.



Жилд нэг удаа 12 цагийн турш аллагын гэмт хэргийг зөвшөөрдөг Цэвэрлэгээний хуультай байна. Өмнө нь цагдаагийн дэслэгч байсан Барнес хүүгээ алсан хүмүүсийн алахгүй өршөөхөөр шийднэ. 2 жилийн дараа ерөнхийлөгчийн сонгуулийн гол өрсөлдөгч, Цэвэрлэгээний хуулийг эцэслэхээр сонгуулийн мөрийн хөтөлбөрөө болгосон Сенатын гишүүн Чарлин Роаны хамгаалалтыг албыг ахлана.



Тусгаар тогтнолын өдрөөр харь гаригийнхан дайрснаас хойш хүн төрөлхтөн тэдний технологийг ашиглан шинэ хамгаалалтын системтэй болно. Гэвч өмнөхөөсөө илүү хүчтэй дайралт ирлээ. Бидний хамгаалалт найдвартай байж чадах болов уу.

ТУН УДАХГҮЙ “ТЭНГИС”-ИЙН ДЭЛГЭЦНЭЭ



Гарах хугацаа 2016.07.08



Гарах хугацаа 2016.07.22



Гарах хугацаа 2016.07.29



Гарах хугацаа 2016.07.29



Гарах хугацаа 2016.08.05